

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-27
1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	4-27

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 09-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 03 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Ариунзаяа, А.Ганбаатар, М.Нарантуяа-Нара;

Томилолттой: Б.Бейсен, Г.Хосбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Ж.Баясгалан, Х.Болормаа, Ж.Галбадрах, М.Энхцэцэг;

Тасалсан: О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн.

Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Г.Батнэмэх, мөн газрын шинжээч Д.Баттогтох, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газрын дарга А.Баярбаатар, “Монгол өмгөөлөгч” Хууль зүйн фирмийн хуульч Б.Оюунтуул, Г.Халиун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Б.Энхмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, О.Саранчуллуун, Д.Ганмаа, Б.Найдалаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч Б.Уянга, Д.Рэгдэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Г.Батнэмэх, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Бум-Очир, Д.Ганмаа, С.Зулпхар, О.Саранчулуун, Б.Найдалаа нар үг хэлэв.

Б.Найдалаа: Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 03 минут.

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Найдалаа: Сайн байцгаана уу. Гишүүдийн энэ өдрийн мэндийг эрье. Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдааныг эхэлье. Гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцэд орсон байгаа гишүүдийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай, Мөнгөнцогийн Ганхүлэг, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Отгоны Саранчулуун, Бадарчийн Хэрлэн, Сүхбаатарын Эрдэнэбат, Дуламын Бум-Очир, Сархадын Зулпхар, Бадрахын Найдалаа, Мягмардашийн Сарнай, Лутаагийн Энхнасан, Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Дүгэрийн Рэгдэл, Банзрагчийн Түвшин, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирж, хуралдааны ирц бүрдсэн байна. Ирц танилцуулж дууслаа. Ирц бүрдсэн учраас Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 12 сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр хэлэлцэх одоогийн байдлаар 1 асуудал байгаа.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Г.Хосбаяр нарын 3 гишүүн 2025 оны 7 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Энэ хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн байна уу. Алга байна. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Өмнөх Байнгын хорооны хурлаар бид нар тогтоол гаргасан байгаа. Тэр тогтоол дээр оруулсан саналтай холбоотой маргаан үүсэж байгаа болохоор тэрийг бас энэ дээр яримаар байна.

Б.Найдалаа: Тэрийг Саранчулуун гишүүн яг саналуудыг эргээд тусад нь ярья. Ажлын шугамаар ярья. Яг энэ Байнгын хорооны хэлэлцэх асуудалд оруулаад ярих нь зохисгүй бөгөөд бас яг тохиромжгүй байгаад байна.

Тэгэхээр энэ хэрвээ тогтоол дээр өөрчлөлт орохоор бол эсвэл саналыг дутуу авсан бол хэдүүлээ тусад нь ажлын шугамаар ярилцаад, хэрэгтэй бол дараагийн Байнгын хороогоор дахиж засварлачихъя. Тэгэхээр ойлголоо Саранчулуун гишүүн ээ. Тэгээд яг саяынхаараа хэдүүлээ ярилцаад, хэрвээ шаардлагатай бол дараагийн Байнгын хороогоор оруулаад явъя. Өөр саналтай гишүүн байна уу. Алга байна. Тэгэхээр хэлэлцэх асуудалдаа орёе.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулна.

Тэрнээс өмнө ажлын хэсгийг танилцуулъя. Танилцуулгатай холбоотой ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Дээд боловсролын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Г.Батнэмэх, Боловсролын яамны Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын шинжээч Д.Баттогтох, Төрийн худалдан авах үйл ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газрын дарга А.Баярбаатар, “Монгол өмгөөлөгч” хууль зүйн фирмийн хуульч Б.Оюунтуул, “Монгол өмгөөлөгч” хууль зүйн фирмийн хуульч Г.Халиун нарын ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Одоо танилцуулга хийх Уянга гишүүнийг урьж байна. Уянга гишүүний микрофоныг нээе.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуулийн зорилт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хувийн хэвшлийн оролцоо, төрийн дэмжлэг, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг баталсан. Тодруулбал, 2 дугаар зорилтын 2.1.27-д “шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд дээд боловсролын сургалтын байгууллагуудын оруулах хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлж, бүс нутагтаа өрсөлдөх чадвартай Үндэсний судалгааны их сургууль байгуулна.” 2.4.4-д “шинжлэх ухаан, инновацын салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож, гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ.” 2.4.15-д “Шинжлэх ухаан, технологийн санд олон улсын адил төстэй сангуудын жишиг хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна.” гэж тус тус заажээ.

Хэдийгээр Шинжлэх ухаан, технологийн тухай хууль болон “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжилтийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэх, Шинжлэх ухаан, технологийн санг олон улсын адил төстэй сангуудын жишиг хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна гэж тус тус заасан боловч улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх аливаа тендер, сонгон шалгаруулалтад Шинжлэх ухааны академи төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага болон их, дээд сургуулийн багш, эрдэмтэд оролцох боломж эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Тодруулбал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “захиалагч тендерийн баталгааг төсөвт өртгийн 0,5 хувиар тогтооно.” Мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.” хэмээн тендерийн төсөвт өртгөөс хамааруулан тендерийн болон гүйцэтгэлийн баталгааг оролцогчоос гаргуулах зохицуулалттай.

Шинжлэх ухааны академи, төрийн өмчийн их, дээд сургууль эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаач, багш нарын хувьд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй харьцуулахад аливаа тендер, сонгон шалгаруулалтад оролцоход тендерийн болон гүйцэтгэлийн баталгааг гаргахад хөрөнгө, санхүүгийн хүндрэл үүсдэг.

Шинжлэх ухааны академийн хувьд жишээ авч үзэхэд өөрийн эзэмшиж, ашиглаж буй хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг тодорхой хугацаанд барьцаа болгон сонгон шалгаруулалтад оролцох эрх мөн хаалттай байна. Өөрөөр хэлбэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-д “төрийн өмчийг барьцаалах орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах бүрэн эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлнэ.” гэж тус тус заажээ.

Эдгээр зохицуулалтууд нь Шинжлэх ухааны академи, төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага болон их, дээд сургуулийн эрдэмтэд, багш нар оролцох боломжийг хязгаарлаж байгаа тул дээрх хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг явуулах, мэргэжлийн чиглэлээр судалгаа шинжилгээний холбогдох ажил гүйцэтгэхэд дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, нээлттэй болгох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Эрхэм дарга, гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдан гарах хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, дэмжихийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Найдалаа: Уянга гишүүнд баярлалаа. Хуулийн төсөл санаачлагчийн танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Зулпхар гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүнээс эхлэх юм байна. Зулпхар гишүүний микрофоныг нээе.

С.Зулпхар: Би их тийм тодорхой асуулт асууя. Энэ их чухал санал орж ирж байна. Ялангуяа жишээ нь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд дээр өөрийн онцлогтой. Судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийдэг. Тэгээд энэ бол Төрийн худалдан авах үйл ажиллагааны хуультай уялдаад нэг талдаа их тийм бэрхшээлтэй 2 дугаарт үндсэндээ бол судалгаа эрдэм шинжилгээний ажил бараг битгий хийгээч ээ гэдэг ийм хаалт болсон ийм зүйлүүд байдаг. Байгууллага өөрөө их онцлогтой. Тэр онцлогтой байдал нь юу гэхээр зэрэг шинжлэх ухаан хөгжүүлэх, шинжлэх ухаан хөгжүүлэхтэй холбоотой тодорхой одоо жишээ нь хэсэг улсуудын

санаачилга байдаг ихэвчлэн. Тэгээд хамаагүй зарлаад л хэн дуртай нь авдаг ч юм уу тийм зүйл бол бас заримдаа байдаггүй. Жишээ нь биологийн чиглэлийн тогтсон эрдэмтэд байхад тэд нар л хийдэг ажил байдаг иймэрхүү хүндрэлүүд хаа сайгүй гардаг байсантай холбоотой энэ асуудлыг шийдэхээр манай Их Хурлын гишүүд маань санаачлаад ийм хууль оруулж байгаа юм байна.

Миний асуулт бол энэ Худалдан авах үйл ажиллагааны хуультай уялдсан байдлаар та бүхэн яаж харж, тэн дээр бас ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт орж байгаа юу гэсэн ийм асуулт байгаа юм. Би нөгөө хуулийн төслийг бүрэн танилцаагүй байгаа учраас та бүхнээс мэдээлэл авъя.

Б.Найдалаа: Уянга гишүүн хариулах уу. Рэгдэл гишүүний микрофоныг нээе. Тэгээд дараа нь худалдан авах газраас.

Д.Рэгдэл: 2024 оны 6 сард Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн 31.5 дээр суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг чиглэлээр зарлагдсан худалдан авах үйл ажиллагаанд эрдэм шинжилгээний байгууллага шууд гэрээгээр оролцож болно гэсэн агуулгатай заалт байгаад байгаа юм. Тэгэхдээ зэрэг үүнийг шууд гэрээ байгуулаад ийм ажил гүйцэтгэх гэхээр цаад захиалагч тал эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ хийх дургүй. Ингээд заримдаа тендерийн баталгаа шаардана. Сая Уянга гишүүн ярилаа. Заримдаа гүйцэтгэлийн баталгаа шаардана. Тэгээд тэрэнтэй нь уялдуулаад хэдийгээр Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд 31.5-д заагаад өгчихсөн боловч одоо ийм баталгаа шаардахгүй гэсэн заалтуудыг Шинжлэх ухаан, технологийн хуульдаа нэмж оруулж өгье гэж байгаа юм.

Тэгэхээр бол баталгаа шаардахаа болино. Энэ тухай бол бид нар худалдан авах товчхон хэлчихье. Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг оруулж ирж байгаа юм. Энд үндсэндээ бол 1 дүгээр зүйл дээр 2 заалт, 2 дугаар зүйл дээр 1 заалт, 3 дугаар зүйл дээр 1 заалт, тэгээд 2 дугаар зүйл гээд дахиад ороод ирж байгаа юм. Ямар, ямар заалт оруулж байна гэхээр энэ бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 3.3.8 дээр Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 23.4-д заасан төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зохицуулалтын ажлыг гүйцэтгэх харилцаа гэж орж ирж байгаа. Энэ бол нөгөө бараа, ажил, үйлчилгээ худалдах худалдан авах тухай хуулийн хамрах хүрээнд саяын хэлсэн үйл ажиллагаа бол орохгүй л гэсэн санаа. Шууд гэрээ байгуулж болно гэж. Тэгээд цаашаа явуулаад мөн хуулийн 14.9 дэх заалтыг нэмж оруулж байгаа. Энэ нь бол тендерийн баталгаатай холбоотой заалт. Тэгээд төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад энэ 14 дүгээр зүйл хамрахгүй гэсэн дахиад тендерийн баталгаа, тэгээд дараагийнх нь болохоор дахиад 42.10 дахь хэсэг. Энэ бол гүйцэтгэл, зүгшрүүлэлтийн хугацааны баталгаа гэсэн ийм зүйл байгаа юм. Тэр дээр нь энэ 42.10 гэсэн заалт нэмээд, төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад энэ гүйцэтгэлийн баталгааны тухай заалт хамрах хамаарахгүй гэсэн ийм үндсэн нэмэлт, өөрчлөлт оруулъя гэсэн ийм төсөл орж ирж байгаа. Зүгээр яах вэ 2 дугаар зүйл нь бол хуулийг мөрдөх хугацааг нь заачихсан ийм л заалт ороод орж ирж байгаа.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн тодруулах байх. Тэрнээс наана асуултад худалдан авах үйл ажиллагааны газартай холбоотой асуулт байсан. Болсон уу. Тэгвэл дараагийн гишүүн асуултаа асууя. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Сайн байна уу. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага гэж байгаа. Энд яг манайд хэдэн байгууллага, ямар ямар байгууллагууд харьяалагдах асуудал вэ гэдгийг тодруулъя. Яг хэдүүлээ нэрлэвэл илүү хүмүүст бас ойлгомжтой болох гээд байгаа. Тэгэнгүүт энэ хууль дээр sudalga.gov.mn гээд үндэсний платформ нь ажиллахгүй байгаа учраас энийгээ бас сайжруулах үр дүн гарах юм байна гэж ойлголоо. Тэгэнгүүт sudalga.gov.mn сайт руу төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн судалгааны ажлыг бүрэн гүйцэд оруулахдаа ямар шалгуурыг тавьдаг юм. Улсын төсвөөр хийсэн бол орох юм уу. Эсвэл нөгөө импакт фактортай сэтгүүлтэй, судалгааны үр дүнтэй юмыг ингэж оруулах юм уу. Академик шалгуурын хувьд ямар ямар шалгууруудыг энэ дээр оруулах вэ гэдгийг бас асууя.

Тэгээд бараа, үйлчилгээ гэдэг дотор оффисын ширээ сандал болон эд хөрөнгийн ямар ямар зүйлүүд бүгд энэ дээр бас харьяалагдах уу. Хамт орох уу гэдгийг бас асууя.

Б.Найдалаа: Хэн хариулах вэ. Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Тэгэхээр төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага гэдгийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заачихсан байгаа. Энд үндсэндээ 4 төрлийн байгууллага орох гээд байгаа юм.

1 дүгээрт Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхэлдэг хүрээлэн, төв лаборатори энд шууд орж байгаа.

2 дугаар хэсэг газар бол Дээд боловсролын тухай хуулийн 22.4-д заасан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага. Өөрөөр хэлбэл эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарч байвал их сургуулиуд орно гэсэн үг. Эрдэм шинжилгээний байгууллага төрийн өмчит.

3 дахь нь бол Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл гээд байгаа юм. Энэ нэгдлүүд бол цөөхөн ганц нэг тийм корпорац маягийн нэгдлүүд байгаа.

4 дэх нь бол төрийн болон орон нутгийн музейнүүд бас төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагууд хамарна гэсэн. Ийм байгууллагууд хамарч байгаа

2 дахь асуулт нь ямар асуулт байна. Тэр судалгаа гэдэг Засгийн газрын Хэрэг эрхлэх дээр тийм sudalga.gov.mn гэсэн сайт байж байгаа. Тэгээд тэн дээр бол бид нар Засгийн газрын Хэрэг эрхлэхтэй хамтраад тэнд орсон бүх судалгааны ажлын жагсаалт, агуулгатай нь танилцсан байгаа. Тэгэхээр тэнд бол ямар нэгэн шалгуур тавилгүйгээр ерөөсөө л нутгийн удирдлагын байгууллагууд, Засгийн газрын агентлагуудаар зарласан суурь судалгаануудын материал голцуу орж байна. 1 дүгээрт.

2 дугаарт Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хэрэгждэг зарим нэг төслийн үр дүн орж байна. Тэгээд тэнд бол одоогоор бид нарыг хамтарсан судалгаа хийж байхад 1500 орчим судалгааны юм орсон байгаа. Материал. Тэрний ер нь бараг 3-ны 1 нь бол яг тэр судалгаа хөгжүүлэлт буюу RND гэдэгт хамрахгүй

материалууд ороод байгаа юм. Нэг талаас. Нөгөө талаас энэ Шинжлэх ухаан, технологийн сан дээр байдаг сангаас санхүүжиж байгаа, санхүүжсэн судалгааны тайлангуудаас зүгээр ямар тайлан нь орсныг бүү мэд. Цөөн тайлангууд орчихсон. Ихэнх нь огт ороогүй. Тэгэхээр энэ sudalгаа.gov.mn -ийг Шинжлэх ухаан, технологийн сан дээр байж байгаа тэр тайлангуудын мэдээлэлтэй нийлүүлээд ингээд бүрэн мэдээлэлтэй ийм сан байгуулах нь чухал юм байна гэсэн ийм л санаа яваад байгаа.

Ер нь цаашдаа Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт орчихсон шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах асуудал руугаа энэ мэдээллүүдийг нэгтгэж оруулаад, нэгдсэн 1 сантай больё. Тэр санг бол одоо энэ хэрэгжээд явж байгаа, хагас дутуу ажиллаж байгаа мори гэдэг платформ дээр үндэслэж зохион байгуулах ийм л ажил хийгдээд байгаа юм. Тэгээд тэр санааг л албажуулж өгч байгаа. Өөрөөр хэлбэл sudalгаа.gov.mn дээр чинь бол ер нь бараг л материалаа оруулах асуудал сайн дураараа явагдаад байх шиг байгаа юм.

Б.Найдалаа: Уянга гишүүн.

Б.Уянга: Одоо яг ямар ажлуудыг хийлгэх талаар хуулийн төсөлд өөрчлөлт оруулж байгаа вэ гэж асуулаа. Ийм ажлуудыг хамруулахаар төсөөлөн хуульд өөрчлөлтийг оруулж байгаа. Түүнд нь, шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажил гэж орж байгаа юм. Гэхдээ таны түрүүний хэлсэн зүйл бас бодууштай. Улсын төсвөөр зарлагдаж байгаа аливаа төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай тендерт оролцоход гүйцэтгэлийн болон тендерийн баталгааг авахгүй гэгчхэнгүүт өөр төрлийн ажил руу орж ирэх вий дээ гээд. Тэгэхээр хэлэлцэх эсэхийн дараа мэдээж ажлын хэсэг гараад ажиллаад явна. Тэр дээр нэлээн сайн хөндөгдсөн заалтууд дээрээ хайрцаглаж өгөх ёстой байх.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулж асууна.

О.Саранчулуун: Яах вэ, миний тодруулах гээд байгаа зүйл энэ хууль дээр байгаа гарах энэ өөрчлөлтүүд нь одоо байгаа МУИС, ШУТИС, АШУИС гээд энэ ТӨҮГ гэдэг нэртэй билүү манай их дээд сургууль. Тэгэхээр тэд нартай маань ер нь хэр хамааралтай вэ гэдэг асуудал байгаа байхгүй юу.

2-т гэвэл шинжлэх ухаан энэ академик салбар маань өөрөө бид нар тэрийг Засгийн газар өөрсдөө сайн, мууг нь эрэмбэлэх биш, тэр чинь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрэмбийн тогтолцоотой академик хэмжүүртэй ийм зүйл шүү дээ. Ер нь бол шинжлэх ухаан бол өөрөө. Тэгэхээр төрийн оролцоо энэ дээр өөрөө ранклаад, өөрөө энийг нь оруулна гэхээсээ илүү тэр орчныг нь бүрдүүлж өгөх талын юм энэ дээр байна уу л гэж хараад байгаа байхгүй юу. Их сургуулийн эрдэмтэд бол Шинжлэх ухаан, технологийн сан, хүрээлэнгүүдээс гадна их сургууль дээр маш олон чадалтай эрдэмтэд байгаа шүү дээ. Тэгэхээр тэд нарт энэ хэр ээлтэй тусах бол гэдэг тийм зүйлийг би хайж асууж байгаа байхгүй юу.

Б.Найдалаа: Хариултыг Уянга гишүүн.

Б.Уянга: Төрийн өмчийн их, дээд сургуулиудыг оруулж байгаа. Тэгээд сая яг Байнгын хорооны зөвлөхүүдтэй, референтүүдтэй ярьж байлаа. Одоо бол оруулж байгаа байдал нь 18.2.2-ыг хөндөж байгаа. Тэнд болохоороо ер нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18 дугаар зүйлд нь эрдэм шинжилгээний

байгууллагуудыг тодорхойлсон байдаг. Тэрний 2.2-т нь Дээд боловсролын тухай хуулийн 4.1.4-д заасан судалгааны их сургуулийг гээд тодорхойлолтоор оруулсан. Гэхдээ ер нь бол Байнгын хороодын ахлах зөвлөх, зөвлөхүүд нэлээн чадварлаг байдаг гэдэг нь түрүүн бас баталгаа болсон л доо. Яг ингээд орчих юм бол зарим нэгэн заалтуудтай нь яг төрийн өмчийн их дээд сургууль түрүүн таны нэрлэсэн МУИС, ШУТИС, АШУИС гээд. Тэдгээр сургуулиуд улсын төсвөөр зарлагдаж байгаа тендерт орох бас эрхийг нь нээх энэ зохицуулалт арай бүрэн хангагдаж уншигдахгүй байна гээд байгаа юм. Тэгэхээр ажлын хэсэг байгуулагдаад явахаараа энэ 18.2.2-ыг нэлээн сайжруулах хэрэгцээ бол үүсэж байх шиг байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Асуулт асуух гишүүнд хуралд авчихсан болохоор нэрээ өгч амжаагүй Ганмаа гишүүнийг нэмээдхээрэй. Энэ хооронд би 1 асуулт асууя.

Яах вэ бид нар яг одоогийн байдлаар одоогийн нөхцөлдөө тааруулаад үзэх юм бол энэ хуулийн өөрчлөлт зөв байгаад байгаа байхгүй юу. Зөв. Гэхдээ та бүхнээс зарчмын талаас нь 1 асуулт асуумаар байна. Яагаад гэвэл одоо жишээлбэл санхүүгийн боломжгүй төрийн өмчит болохоороо, мөнгөгүй болохоороо ч юм уу тийм болохоороо тэр баталгааг нь ч юм уу тэр талаас нь хөнгөлөлт үзүүлье гэсэн юм ярьж байна шүү дээ. Шинжлэх ухааны байгууллагад. Төрийн өмчит шүү. Иймэрхүү байдлаар дутууг нь хуулиар ингээд нөхөөд байх юм бол энэ жагсаалт чинь цаашдаа тасралтгүй нэмэгдээд явахгүй юу. Орон нутгийнх болохоор, эмэгтэйчүүдийнх болохоор, юу гэдэг юм. Энэ зарчим нь өөрөө зөв үү гэж байгаа юм. Тийм болохоор яг энэ дээр энд хүрэлцэн ирсэн байгаа Эдийн засаг, хөгжлийн яам, Боловсролын яам, Төрийн худалдан авах үйл ажиллагааны газар эндээс маш товчхон байр сууриа та бүхэн бэлдэж байгаарай. Та бүхнээс заавал бодлыг нь асуумаар байна.

Тэгээд төрийн өмчит судалгааны байгууллага гэж байна шүү дээ. Төрийн бус өмчит бас байгаа тийм ээ. Эдгээрийгээ яах билээ. Тэгээд энэ дээр яг зарчим нь зөв үү гэдэг дээр ажлын хэсгийнхнээс болон яг энэ хууль санаачилж байгаа гишүүдээс асууж бас хариулт авах ёстой гэж бодож байна.

Тэгээд төр өөрөө байгууллага байгуулаад, судалгааны байгууллага байгуулчхаад, зардлыг нь гаргана гэххээд эргээд дахиад өөрсдөө мөнгө олж гэдэг юм уу ямар нэгэн байдлаар төрийнх гэдгээр нь давуу тал өгөөд явах нь өөрөө зөв юм уу зарчим нь. Тэгээд судалгааны байгууллага бүгдээрээ төрийнх болчих юм биш үү. Ингээд байх юм бол. Тэр хувийн их сургуулиуд, судалгааны байгууллага яах билээ. Адилхан нөгөө тэгш биш өрсөлдөөн үүсэх юм биш үү. Ингээд яваад байх юм бол бид нар юу гэдэг юм төрдөө давуу тал өгөөд, өөрөө өөрсдөдөө давуу тал өгч байна гэсэн үг шүү дээ. Ингээд явчих юм бол энэ зарчим нь өөрөө зөв үү гэдэг ийм одоогийн асуудлыг шийдэхтэй холбоогүйгээр цаашдаа зүгээр энэ зөв үү гэдэг энэ зарчим дээр хариулт авмаар байна. Энийг Рэгдэл гишүүн болон Уянга гишүүн хариулах уу. Дараа нь нөгөө 3 яамдаас асууя. Яг байр сууриа маш товчхон илэрхийлмээр байна. Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: 1 дүгээр асуулт. Тэгэхээр энэ тендерийн хуулийн үйлчлэх хүрээнд ингээд цуварч ороод,цаашаа баахан байгууллагууд цувраад явчих вий гэдэг болгоомжлол бол хааяагүй байгаа. Бид нар энэ асуудлыг оруулж ирэхдээ зүгээр цоо шинээр санаачлаад оруулаад ирсэн юм биш байгаа юм. Энэ Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжихээс өмнө мөрдөж байсан хууль дээр яг ийм заалт бол байсан

юм. Төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага шууд гэрээгээр тодорхой ажил гүйцэтгүүлж болно гэсэн. Тэгээд шинэчилсэн найруулгыг хэлэлцэх явцад энэ бол хэлэлцэгдэлгүй хаягдчихаад, тэгээд үүнийг нэг ёсондоо бас эргэж сэргээж оруулж байгаа ийм л заалт байгаа юм.

Яагаад ингэж байна вэ гэдэг нь хамгийн чухал. Яагаад ингэж байгаа юм гэхээр энэ эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байгаа судлаачдад асар их хэмжээний өгөгдлүүд байна, мэдээ мэдээлэл байна, туршлага байна. Тэгэхээр тэд нарын байгаа тэр мэдлэг мэдээлэл, өгөгдлийн нөөцийг зөв судалгаа гаргаж, зөв дүгнэлт гаргахад ашиглах ёстой юм гэдэг утгаар нь бол ингэж оруулж ирээд байгаа. Нэг талаас. Нөгөө талаас мэдээж хэрэг бид нар эрдэм шинжилгээ, шинжлэх ухаан технологийн салбарын зардлыг ДНБ-ий 1 хувьд хүргэнэ гэххээд 2025 оны байдлаар 0.12 хувийн ДНБ-ийг өгөөд яваад байгаа. Энэ хэмжээгээ дээшлүүлэхэд энэ бараа, ажил, үйлчилгээ, өөрөөр хэлбэл энэ тендерийн хуулийн явцад тодорхой орлого олоод, төрөөс эрдэм шинжилгээний байгууллагад олгох санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх юм гэсэн ийм тооцоотой яваад байгаа. Яагаад төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага гэж онцолж үзээд, хувийн хэвшлийнхийгээ хаяад явчхаад байна вэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр одоогийн байдлаар манай улсад яг бүтэн цагийн эрдэм шинжилгээний ажилтнууд бол 1700 гаруй ажилтан байна. Энэ 1700 гаруй ажилтны дотор төрийн бус өмчийн хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний 4 байгууллагатай. Тэнд бол үндсэндээ 100 гаруй эрдэм шинжилгээний ажилтан байдаг. Тэд нар бол бас харьцангуй шинэ байгуулагдсан, мэдээллийн болоод туршлагын нөөц багатай. Цаашдаа бол ялгаа байхгүй энэ төрийн бус өмчийн эрдэм шинжилгээний байгууллагууд энэ рүү орж ирэх зам бол нээлттэй байх болов уу л гэж ингэж бодоод байгаа.

Тэгээд энд 1 чухал юм бол энэ худалдан авах үйл ажиллагаанд эрдэм шинжилгээний байгууллага орохдоо үндсэндээ өдийг хүртэл явж ирсэн замнал бол үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийн дагуу л ордог байсан. Үндсэн чиглэлээс өөр чиглэлээр бол ордоггүй байсан. Тэгээд энэ нь цаашдаа үүгээрээ явах уу эсвэл болих уу гэдэг нь бас энэ хуулийн хэлэлцүүлгийн явцад тодрох болов уу гэж ингэж бодож байгаа.

Б.Найдалаа: Уянга гишүүн.

Б.Уянга: Найдалаа дарга аа, одоо яг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн орчны хүрээнд төрийн өмчийн 6 их, дээд сургууль, Шинжлэх ухааны академи, улсын төсвөөс зарласан тендерт орж чадахгүй байгаа нь асуудал байгаа байхгүй юу. Одоо ордог байхад нь хувийн хэвшлээсээ давуу эрх олгох гээд байгаа хүсэл эрмэлзэл энд ерөөсөө байхгүй. Харин оруулдаг больё. Оруулаад хувийн хэвшилтэйгээ хамтдаа өрсөлдөөд, тендерээ ав. Тэгээд тендерээ аваад үйл ажиллагаагаа хийлээ гэхэд төр өөрийнхөө карманаас нөгөө тал руугаа гүйцэтгэлийн баталгаа гэж мөнгө өгөхөө больё. Тэртээ тэргүй төрийн өмчийн гэсэн статустай байгаа бол тэдгээрийг нь төлөхгүйгээр ажлаа хий гэж байгаа юм. Тэгээд яах вэ тендерт ингээд оролцлоо гээд гүйцэтгэлийн баталгаа тавья гэнгүүт төрийн өмчит аливаа өөрсдийнхөө эзэмшдэг хөрөнгийг барьцаалах асуудал үүснэ. Ихэвчлэн мөнгө байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгтэл тэр нь Улсын Их Хурлын .../минут дуусав/

Б.Найдалаа: Ойлголоо. Яах вэ, эргэлзээд байгаа 1 зүйл байна л даа. Зорилгыг нь ойлгож байна. Жишээлбэл түрүүн Рэгдэл гишүүн хэлсэн. 71 шинжлэх ухааны байгууллагаас 4 нь хувийнх гэж байна шүү дээ. Тэгээд хувийнхыг нь шууд хаяад

бусад 67-д нь зүгээр давуу эрх өгөх гэж байгаа. Нөгөөдүүл нь мөнгөтэй юм уу, эсвэл хамаагүй юм уу, эсвэл яваандаа бүгдээрээ төрийнх болоорой гэсэн бодлогын чиглэл хөшүүрэг юм уу. Тэр нь ойлгомжгүй болчихоод байна. Түүнээс би зарчмуудыг дэмжээд, хуулийг бол дэмжиж байна. Зүгээр яг саяынхыг хэрвээ бид нар буруу зохицуулалтаар зөв бодлогыг хийх гэж оролдох юм бол сөрөг үр дагаварт хүргэчих вий дээ л гэж санаа зовоод байгаа юм л даа. Тэгээд бид нар Байнгын хороон дээр сайн хэлэлцэж байж явах ёстой болохоор л би асууж байгаа юм шүү. Түрүүн хэлдэг нөгөө яамдаас товчхон саналыг нь сонсьё. Энэ яг бодлогын хувьд та хэдийн барьж байгаа, хэрэгжүүлж байгаа бодлоготой яг уялдаж байгаа юм уу. Зөв юм уу. Боловсролын яам, Сангийн яам, Төрийн худалдан авах үйл ажиллагааны газар, Эдийн засаг, хөгжлийн яам. Эдийн засаг, хөгжлийн яамнаас эхэлье. Хамгийн том, гол бодлого барьж байгаа яам. Хэн билээ. Микрофон хэд вэ. Микрофон 6.

Б.Мөнхтөр: Найдалаа даргын асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Мөнхтөр. Шинжлэх ухаан, технологийн бодлого төлөвлөлтийн газрын даргын албыг хашиж байгаа хүн байна. Тус хуулийн төслийн хувьд бол зарчим талаас нь бол дэмжиж байгаа. Ер нь бид нар бол шинжлэх ухааны байгууллагуудаа улсын төсвийн хөрөнгөөр, хөрөнгө оруулалтаар бол хангалттай түвшинд дэмжиж бол чадахгүй байгаа. Тэр учраас төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тодорхой хувийн хэвшил дээр байгаа болон улсын төсвийн хөрөнгөөр зарлаж байгаа судалгааны ажлуудаар оролцож энэ бол нөгөө тендерээ хуулиар тендер зохион байгуулалтаар яваад байгаа л даа. Тэгээд энд оролцож юу гэдэг юм, төсөл хэрэгжүүлэх боломжийг нь нээж өгөхгүй бол бас богинохон хугацаанд энэ шинжлэх ухааны салбарыг босгож ирэхэд бас хүндрэлтэй. Нөгөө талаасаа энэ боломжийг нээж өгснөөрөө айхтар хавтгайрсан дэмжлэг бол болчихгүй. Ер нь бол шинжлэх ухааны байгууллагууд маань, хүрээлэнгүүд маань өөрсдөө бол яг өөр өөрийн чиг үүргийн хүрээний судалгааны чиглэлдээ л оролцоно. Жишээ нь физикийн чиглэлийн тендер төслүүд ороод ирлээ гэж бодоход улсын хэмжээнд ердөө 2, 3 чиг үүргийн байгууллага л байгаа. Физик, технологийн хүрээлэн ч байдаг юм уу, Цөмийн судалгааны төв. МУИС-ын хажууд байж байгаа гэх мэтчилэн. Геологийн гэхэд бол ганц хоёрхон л байгууллага байж байгаа. Геологийн хүрээлэн ч гэдэг юм уу. Тэгэхээр маш явцуу хүрээнд энэ өөрөө хэрэгжих учраас айхтар тийм хавтгайрсан ойлголт бол үүсчихгүй байх гэж бодож байна. Зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Боловсролын яам. Микрофон 6.

Г.Батнэмэх: Боловсролын яамны Дээд боловсролын газрын ахлах шинжээч Батнэмэх байна. Асуултад хариулъя. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль дээр ямар ямар байгууллагууд энэ хуульд хамрагдах вэ гэдгийг түрүүн Рэгдэл гишүүн хэлсэн. Энэ дээр 18.2 дээр Дээд боловсролын тухай хуулийн 22.4-д заасан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамрагдах дээд боловсролын байгууллага орно гэсэн байгаа. Дээд боловсролын тухай хуулийн 22.4-д юу байгаа вэ гэхээр их сургууль нь өөрийн үндсэн бүтцэдээ эрдэм шинжилгээний хүрээлэн, сургалт, судалгааны бизнес инкубатор, технологийн дамжуулах төв, гарааны байгууллага болон бусад байгууллагууд байна гэж заасан байгаа. Ийм учраас зарчмын хувьд бол манайх дэмжиж байгаа. Тэгээд түрүүн Эдийн засаг, хөгжлийн яамны хэлсэнчлэн өөр өөрийн чиг үүргийн хүрээнд тендерт оролцох учраас энэ бол боломжтой гэж үзэж байгаа.

Дээд боловсролын тухай хуулийн 22.4 дэх заалт дээр бол төрийн болон төрийн бус өмчийн гэж ялгасан зүйл бол одоогоор байхгүй байгаа.

Б.Найдалаа: Сангийн яам хаана байгаа билээ. Микрофон хэд вэ. 2.

Ц.Батзул: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйл дээр зарчмыг заасан байгаа. Зарчим дээр өрсөлдөх тэгш боломжтой гэж байгаа. Тэгэхээр яг энэ хууль санаачлагчийн боловсруулсан хуулийн төсөл дээр логик зөрчилтэй 1 заалт байна. Тэгээд зарчимтай зөрчилдөж байгаа 2 заалт байна.

Эхнийх нь бол үйлчлэх хүрээнээс гаргачихсан мөртөө хуулийн дагуу шаардаж байгаа баталгааг ирүүлэх шаардлагагүй гэхээр энэ 2 маань зөрчил болчхож байгаа юм. Тэгэхээр яагаад гэхээр энэ хуулийг энэ үйл ажиллагаанд хамаарахгүй гэж томьёолоод, 3.3-аар орж байгаа мөртөө баталгааг ирүүлэх шаардлагагүй гэхээр. Тэгэхээр нэгэнт энэ хуулийг мөрдөхгүй гэж томьёолж байгаа юм бол энэ хуулиар шаардаж байгаа баталгаа шаардах нь өөрөө ач холбогдолгүй, логик зөрчилтэй болчхож байгаа юм.

2 дугаарт тендерийн хуулиар ер нь бол цаашид хувийн хэвшил болон төрийн хэвшилтэй хоорондоо өрсөлдөхгүй гэдэг бодлогын хүрээнд өрсөлдөх тэгш боломжтой гэдэг зарчим үйлчилж байгаа. Үүнтэй бол шууд зөрчилдөхөөр харагдаж байна. Тэгээд сүүлд 2023 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа хөрөнгөө барьцаалах боломжгүй хуулийн этгээдүүдийн хувьд бол даатгалын үйлчилгээгээр баталгааг дүйцүүлэн тендерт оролцох боломжтой байдлаар хуулийн 14 дүгээр зүйл дээр зохицуулчихсан. Мөн 42 дугаар зүйл дээр зохицуулчихсан байгаа. Тэгэхээр шинжлэх ухааны байгууллагууд маань яг тендер шалгаруулалт оруулахад даатгалын сертификат ирүүлэх замаар хөрөнгөө барьцаалалгүйгээр үйлчилгээ авч, тендерт оролцох эрх нь бол нээлттэй байгаа. Энэ маань 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс мөрдөөд явж байгаа хууль байна.

3 дугаарт энэ томьёолол дээр болохоор Засгийн газар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэж заасан байгаа. Тэгэхээр жишээ нь Их Хурлаас энэ академитай харилцаанд орохоор бол энэ хууль мөрдөхөөр болчхож байна. Шүүхийн байгууллагууд мөн академиар судалгаа хийлгэхээр бол бас энэ маань дахиад мөрдөхөөр болчхож байгаа. Тэгэхээр энэ маань яагаад заавал Засгийн газар эсвэл төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой эсвэл орон нутгийн өмчит компаниуд дээр үйлчлээд шүүхийн байгууллагууд, Их Хурлын байгууллагууд дээр энэ маань яагаад үйлчлэхгүй байгаа юм бэ гэдэг бас зарчмын асуудлууд гарч ирээд байгаа юм. Үндсэндээ бол энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарчимтай зөрчилдөж байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа Сангийн яамнаас байгаа юу. Саналаа хэлчих. Яамны байр суурь гэсэн үг шүү дээ. Микрофон 1.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам, Зарлагын хэлтэс Бат-Эрдэнэ. Найдалаа даргын асуултад хариулъя. Тэгэхээр энэ яг манай газар, хэлтсийн хариуцдаг чиг үүргээс арай өөр асуудал байгаад байгаа. Худалдан авах нь. Тэгэхээр би Байнгын хорооны хурлын дараа Байнгын хорооны ажлын албаар дамжуулаад, танд яг энэ асуултыг нь худалдан авах ажиллагааны бодлогоо хариуцдаг хэлтсээс нь зохих хариултыг нь аваад танд хүргүүлъя.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгээд энэ ойлгомжтой хууль юм шиг боловч бас саяын хэлж байгаа тэр зарчмын зөрүүтэй, логикийн, бодлогын зөрүүтэй асуудал бол байгаа байхгүй юу. Хуулийн төслийн санааг бол дэмжиж байгаа. Гэхдээ яг Монгол төр иймэрхүү бодлого хийж байгаа нь өөрийнхөө бодож байгаа юмтайгаа үйлдэл нь таарч байна уу гэдэг дээр сайн бодох ёстой юм байна. Тэгэхээр өнөөдөр Байнгын хороогоор ямар шийдвэр байх нь хамаагүй. Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдэхэд ялангуяа яам хариуцсан нэгж биш гэлгүйгээр сайдаа дагуулдаг юм уу, засгийнхаа түвшинд яг бодлогоо нэгтгэж орж ирэхгүй бол хуулийн төсөл явах нь байна шүү. Сая Мөнхтөр даргын хэлж байгааг би бол сайн ойлгохгүй байна яг үнэндээ бол. Монгол Улсын хөгжлийн бодлогыг барьж байгаа яамнаас жишээлбэл Шинжлэх ухааны академийг дэмжиж нэг их чадахгүй байгаа болохоор ерөнхийдөө ажил хийж байг дээ гэсэн маягтай байр суурь хэлж байгаа байхгүй юу. Энэ бол Монгол Улсын Засгийн газрын байр суурь ийм байх ёсгүй байх. Шинжлэх ухааны академи чинь судалгааны байгууллага байгуулаад, санхүүжүүлнэ гэхихсэн, зорилгыг нь тавьчихсан. Тэгээд хүн цалинжуулаад ажиллуулж байгаа бол нэг бол санхүүжүүлэх, нэг бол шударгаар өрсөлдөх тиймэрхүү нөхцөлөө бүрдүүлэхгүй бол яах вэ, иймэрхүү байдлаар мөнгө олж байг гэсэн байр чинь өөрөө явуулж байгаа бодлого, үйлдэл 2 нь зөрчөөд байгаа байхгүй юу. Тэгээд энэ заавал хаа нэгтээ очиж нэг асуудал үүснэ гэж би бол бодож байна. Тэгэхээр энэ дээрээ дараагийн нэгдсэн хуралдаанаар орохдоо ч юм уу, тодорхой мэдээлэлтэй, хариулттай орохгүй бол гишүүд асуух байх. Хэн хариулах билээ. Рэгдэл гишүүн хариулах уу.

Д.Рэгдэл: Сая тэр хуулийн заалтуудын зөрчлийн тухай асуудлаар Худалдан авах ажиллагааны газраас ярилаа. Тэгэхээр энэ Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 30.5 дээр заачихсан байгаа юм. Засгийн газар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд энд оролцож болно. Тэгэхээр Засгийн газар гэдэг нь явж явж энэ Засгийн газрын бүх бүтцийн байгууллагууд эд нар бол энэ үйл ажиллагаанд оролцож, эрдэм шинжилгээний байгууллагаар захиалгатай судалгаагаа хийлгэж болно л гэсэн санаа. Тэр нь орохгүй, тэр нь орно гэж ялгасан юм байхгүй. Аль нь ч орж болно. Зүгээр яагаад бид нар тендерийн баталгаа шаардахгүй, шууд гэрээгээр хийнэ гэхихсэн байгаа шүү дээ. Гэсэн атлаа дараа нь нэмээд тендерийн баталгаа шаардахгүй, гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй гэдэг заалт оруулж ирж байгаа вэ гэхээр энэ нэр дурдсан байгууллагууд зарлалдчихаад оролцъё гэхээр ... /минут дуусав/

Б.Найдалаа: Рэгдэл гуай баярлалаа. Нөгөө микрофон байхгүй. Та чинь яг сайхан микрофонтой юм шиг ярьдаг болохоор мэдэхгүй суугаад байсан байна. Рэгдэл гишүүн ээ, энэ хуулийг дэмжиж байгаа шүү. Зүгээр яах аргагүй томьёоллын хувьд болон зарчмын хувьд цаашдаа зүгээр тийм буруу жишиг сөрөг болох вий л гэж асууж, шалгаагаад байгаа юм. Тэгээд хувийн хэвшил төрийн хэвшил гэж ялгаж угаасаа хуульд заах нь өөрөө их осолтой зүйл байгаад байгаа юм. Яагаад гэвэл тэр чинь аажимдаа хувийн хэвшлийн судалгааны байгууллага эрдэм шинжилгээний эрдэм шинжилгээний байгууллага байх шаардлагагүй мэт тийм бодлогын чиглэл, луужинг өгөх гэж бичих гээд байгаа юм шиг санагдаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бол болгоомжтой байх ёстой байх. Ганмаа гишүүний асуултыг аваад тэгээд нэмээд минут өгчихье.

Д.Ганмаа: Баярлалаа. Шинжлэх ухаан, технологийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ төслийг бол дэмжиж байна. Их гоё сонсогдож байна надад бол. Тэгээд сая ярьж байгаа нь ихэвчлэн тендер, худалдан авалтыг тойроод байхаар би бас юу гэдэг юм энэ хайран хууль дээр зөвхөн энийг тойрч ярихаасаа илүүтэйгээр би бас хэдэн ерөнхий юм асууя гэж бодоод байна л даа. Нэгэнт яамных тэгээд юу

гэдэг юм, холбогдох байгууллагын хүмүүс хууль санаачлагчид байгаа учраас энэ хуулийн ер нь өөрчлөлтийн үндсэн зорилго нь яг юунд байсан бэ. Одоо энэ судалгаа инновацын үр өгөөжийг нэмэгдүүлэх юм уу. Засаглалаа сайжруулах юм уу, санхүүжилтийн тогтолцоогоо шинэчлэх юм уу гэдэг юм уу жишээлбэл энэ тал дээр.

Ялангуяа энэ судалгааны чанар юм уу инновац нь Монголд их сул байгаа талаар ч юм уу. Эсвэл яг шинжлэх ухаан, эрдэмтдийн нийгмийн асуудал, цалингийн асуудал, тэгээд санхүүжилтээс хамаараад авч байгаа мөнгө төгрөг, тэгээд нийгэмд ажиллаж байгаа эрх үүрэг, ер нь байр их багатай шүү дээ эрдэмтэд, судлаачид гэхээр. Тэгэхээр зэрэг мэргэжилтэй, мэдлэгтэй, сайн эсвэл тэндээ сургуулиа төгсөөд сураад ирчихсэн хүмүүс энд ирээд ажиллахад бас нөхцөл нь их хэцүү байгаад байдаг. Тэгэхээр энэ тал дээр ямархуу өөрчлөлт шинэчлэлт эсвэл үр ашиг нэмэхээр юмнууд байсан бэ. Олон улсын загваруудаас бас ямар туршлага энд тусгагдсан бэ гэдэг асуулт байгаад байна.

Тэгээд ер нь шинжлэх ухаан, инновац, технологи сайжруулъя гэхээр эцсийн эцэст нөгөө өрсөлдөөнт грант механизмын чанар л олон улсын түвшинд хамгийн өндөр байдаг байхгүй юу. АНУ ч бай, Япон ч бай, Солонгос ч бай бусад эдийн засгийн чадалтай орнуудын хувьд. Тэгэхээр манайд Шинжлэх ухаан, технологийн сан гэж санхүүжилт байгаад байдаг. Мөнгө орж ирэх нь орж ирдэг. Тэгэхдээ тэр мөнгө нь хаанаа ч хүрэхгүй, эсвэл бага, дээрээс нь тэр сонгон шалгаруулалт нь тодорхой биш ил тод бус, тэгээд танил тал мэддэг заримдаа бүр яамаараа ингээд дамжаад явчихдаг гээд яриад байвал асуудлууд зөндөө байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой яг олон улсад жишээлбэл компетитив грант шиг тэр шалгаруулалтыг яаж дэмжих юм, критерийг нь яаж суулгах юм, шалгуур үзүүлэлтээ яаж байх юм, яаж энийг ил тод нээлттэй байх юм. Эцсийн эцэст энэ чинь төсвийн мөнгө, иргэдийн татварын мөнгө шүү дээ. Энэ мөнгийг хэрэгтэй зайлшгүй бид нарт онцгой чухал эрэмбэлэгдэхээр энэ салбар, тэр чиглэл рүү санхүүжих тал дээр бас ямар ямар өөрчлөлтүүд орж байгаа юм гэдэг дээр надад бас асуудал, энэ их сонирхолтой санагдаад байна л даа. Ялангуяа тэрнийхээ хажууд шинжлэх ухааныхаа хажууд нөгөө RD гэж байдаг шүү дээ. Шууд шинжлэх ухаанаас гарсан өөрчлөлтөө хэрэгжүүлээд инновац болгоод, мөнгө төгрөг санхүүжилт үйлдвэрлэх, эдийн засгаа сайжруулах, тэгэхийн тулд уялдаа холбоогоо нэмэгдүүлэх, тэгэх гэж л би Эдийн засаг, хөгжлийн яамны доор очсон гэж бодсон шүү дээ. Гэтэл энэ чинь боловсрол буюу дээд сургуулиудаасаа холдоод, тэгээд дээд сургуулиудыгаа ялангуяа тэнд чинь академик эрх чөлөөтэй илүү .../минут дуусав/

Б.Найдалаа: Минутаа нэмж авах уу. Хариултыг Уянга гишүүн үү. Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Ганмаа гишүүн их чухал асуулт тавилаа. Тэгэхээр энэ зүгээр яах вэ. Судалгаа хөгжүүлэлтийн ажил явуулдаг 2 үндсэн загвар л байгаад байгаа юм л даа. Дэлхий дээр. Үндсэндээ 1 хэсэг нь бол их сургуулиудаараа төвлөрдөг загвар. Америк маягийн. Нөгөөдүүл нь бол академи дээрээ төвлөрч явдаг ийм загвар. Энэ бол ерөнхийдөө Дорнод Европ, Европт бол нэлээн хөгжчихсөн ийм л 2 загвар Манайх бол үндсэндээ академи дээр төвлөрдөг энэ загвар одоо явж байгаа. Энэ нь юун дээр харагдаж байна вэ гэхээр жишээлбэл их сургуулиуд төрийн өмчийн ч бай, төрийн өмчийн бус ч бай тэд нар дээр бол эрдэм шинжилгээний ажилтан гэдэг орон тоо үндсэндээ байхгүй. Багш нар бол давхар ингэж ажиллаад байгаа. Зүгээр энэ хуулийн өөрчлөлт орсноор судлаачдын нийгмийн асуудал, цалин түүнтэй адилтгах орлого дээр яаж нөлөөлөх вэ гэж байгаа юм. Тэгэхээр зэрэг одоо манай Засгийн газраас өгч байгаа лавлагаа дээр бол энэ Засгийн газар, төрийн өмчит үйлдвэрийн

газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд эд нарын шугамаар явдаг энэ судалгаа хөгжүүлэлтийн чиглэлтэй ажилд жилд 60-80 тэрбум төгрөг тавигдаж байна. Тэгэхээр энэ судалгаа хөгжүүлэлтийн ажлыг нь мэргэжлийн байгууллагаар хийлгэвэл 2 ач холбогдол байна гэж үзэж байгаа.

1 дүгээрт бол тэр мэргэжлийн судалгааны байгууллагуудын орлого нэмэгдэнэ. Нөгөө талдаа судалгаа захиалж байгаа байгууллага нь шинжлэх ухааны үндэстэй үр дүн хүлээж авах юм. Ийм учраас энэ хэсэг ажлыг энэ шууд гэрээгээр байгуулдаг тал руугаа явъя гэсэн санаа бол энд явж байгаа.

Монгол Улсын хувьд бол энэ судалгаа хөгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлдэг үндсэндээ ганцхан эх үүсвэртэй. Хууль ёсны. 2023 оноос 2 дахь эх үүсвэр нэмэгдсэн. Энэ нь бол эрдэм шинжилгээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны зардал гэж маш бага хэмжээний мөнгө. Ингээд 2 эх үүсвэртэй юм шиг боловч үндэсний Шинжлэх ухаан, технологийн сангаас л ганц эх үүсвэр гараад байгаа юм. Тэгээд эх үүсвэр энэ судалгаа хөгжүүлэлтийн ажлын эх үүсвэрийг олон болгох зорилго бол энэ хуулийн өөрчлөлтөд бас их шингэсэн юм байгаа юм. Одоо жишээлбэл Америк ч байдаг юм уу эдгээр орнууд чинь төсвөөс явуулдаг судалгаа хөгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлдэг үндсэндээ 7, 8 албан ёсны эх үүсвэртэй байх жишээтэй. Энэ нь бол жинхэнэ өрсөлдөөнийг бий болгохоос гадна орлогын эх үүсвэрүүдийг нь бий болгодог. Бид нар тэр тал руу бас жаахан ойртож явах зорилготой ингээд байж байгаа. Сонгон шалгаруулалтын нээлттэй байдал гэдэг нь бол бид нарын ярьдаг тендерийн хууль бол нээлттэй зарлагддаг. Сонгон шалгаруулалтын аль нь шалгарсан гэдэг нь нээлттэй тавигддаг энэ талдаа бол тэр нээлттэй байдал нь хэвээрээ л хадгалагдана л даа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганмаа гишүүн тодруулж асуух уу. Болсон уу. Тэгвэл Ганмаа гишүүнд микрофон өгөөд, тодруулаад яг тодорхой дахиад нэмээд асуучихъя.

Д.Ганмаа: Уялдаа холбооны тухай асуусан. Энэ Эдийн засаг, хөгжлийн яам дээр очсоноороо шинжлэх ухааны уялдаа холбоо сайжрах уу. Салбар салбарын гэсэн үг. Жишээлбэл нийгмийн эрүүл мэнд талд гэхэд эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, шинжлэх ухаан тэгээд орчны ч гэдэг юм уу ингээд олон юм нэгдэж байж multidisciplinary team гэж бүр нэрлэдэг шүү дээ олон төрлийн судалгаа шинжилгээ баярланд баг бүрдэж байж нэг том асуудлыг шийдэх ч гэдэг юм уу. Одоо тэр уялдаа холбоог хаана, яаж зангидаж явж байгаа вэ гэдэг 1 асуулт байгаад байгаа юм.

2 дахь нь энэ RD гэж байгаа тийм үү. Шинжлэх ухаанаас гарч ирсэн энэ шинэчлэл, инновац, шинэ технологид чинь амьдралд хэрэгжихийн тулд тэр технологи нь шууд амьдралд хэрэгжүүлэхээр ямар юм хуульд туссан юм. Эсвэл ямар санаачилгууд байдаг юм. Одоо нөхцөл байдал яаж байгаа юм.

3 дугаарт нээлттэй сонгон шалгаруулалт гэдэгт нь би зөвхөн худалдан .../минут дуусав/

Б.Найдалаа: Дахиад 1 минут нэмж өгье.

Д.Ганмаа: Жишээлбэл одоо тийм тийм багаас ийм ийм санхүүжилтийг тэдэн төгрөгөөр ингэж олголоо. Олгосон шалтгаан нь ийм ийм байдлаар одоо юу гэдэг юм инновацаа ингэж шийдсэн, импактаа ингэж шийдсэн, шинжлэх ухааныхаа байдлыг ингэж шийдсэн, амьдралд хэрэгжих байдал нь ийм, амьдрал дээр гарах юм нь энэ

гэсэн бүх тооцоолол дүнгүүд нь гарч ирээд, тэр дээр үндэслэсэн тэр санхүүжилт нь орж ирэх энэ механизмыг энд жишээлбэл оруулж ирсэн үү. Үүнтэй холбоотой бичиг баримт, эрдэм шинжилгээний ажил, өгүүллэг эд нар нь бас нээлттэйгээр тэр дата бест ч юм уу, эсвэл нийтэд мэдээлэлтэй ил тод байх боломж нь нээгдэж байгаа юу.

Б.Найдалаа: Эхний асуултыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохих ёстой юм шиг байна. 2 дахь нь бол яг хуулийн төсөлтэй холбоотой Уянга гишүүн хариулаад явъя. 6 дугаар микрофон. Мөнхтөр дарга.

Б.Мөнхтөр: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Юуны түрүүнд бол тогтолцооноосоо эхэлье гэж бодож байна. Яах вэ, ер нь өнгөрсөн хугацаанд нийгэм өөрчлөгдсөнөөс хойш шинжлэх ухааны салбар өөрөө нөгөө өнгөрсөн жилийг хүртэл бол боловсролын тогтолцоотойгоо хамт явж ирсэн. Эдийн засаг, хөгжлийн яам дээрээ шинжлэх ухаан, технологийн салбарын асуудал ирээд одоо бол 1 жил хагасын л нүүр үзэж байна. Энэ нь бол одоо бид нарын бариад байгаа Алсын хараа 2050 ч байдаг юм уу, Шинэ сэргэлтийн бодлого ч байдаг юм уу саяхан хэдхэн хоногийн өмнө батлуулсан улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл ч байдаг юм уу үүнтэй бол бид нийцэж байгаа гэж бодож байгаа. Гол үндсэн шалтгаан нь гэвэл шинжлэх ухааны салбар өөрөө өргөн цар үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Салбар дунд уялдаа холбоог хангах шаардлагатай байдаг. Байгууллага хоорондын уялдааг хангах бодлого боловсруулахад нь үйл ажиллагаа шаардлагатай суурь судалгаа, хэрэглээний судалгааг нь хийж өгөх ийм дэмжлэгүүд нь байдаг. Тэгэхээр яалт ч үгүй тогтолцоо талаасаа Эдийн засаг, хөгжлийн яаман дээр шинжлэх ухааны салбар бол байх нь .../минут дуусав/

Б.Найдалаа: 1 минут гүйцээгээд хариулъя. 6 дугаар микрофон.

Б.Мөнхтөр: Би товчхон хариулъя. Тэгээд түрүүн Найдалаа дарга бас хэлж байна лээ. Энэ чинь аргацаасан зохицуулалт юм биш үү эрх зүйн талаасаа гээд ярьж байна. Энэ бол аргацаасан зохицуулалт бол биш гэж би харж байгаа. Мөнгөн урсгалын эргэлт талаасаа бол Рэгдэл гишүүн нэлээн тодорхой хэлсэн нэлээн том тоо явж байна. Гэтэл бид нар шинжлэх ухааны салбарт яг улсын төсвийн хөрөнгийн дэмжлэг бол бодитой үзүүлж чадаж байна уу гэвэл чадахгүй байгаа. Сүүлийн 5 жилээр гэхэд чинь ер нь эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд бид нар 2020 онд гэхэд 3 тэрбум, 2021 онд 5 тэрбум, 2024 онд гэхэд 13, 2025, 2026 онд гэхэд 10, 10 тэрбум тавьж байна. Гэтэл цаана нь 66 байгууллагын 7 мянга гаран хүн ажиллаж байдаг. Гэтэл энэ хүн судалгаа хийж чадахгүй зүгээр сул цалин аваад байх ийм нөхцөл үүсчхээд байна. Ийм учраас бид нар судалгаа хөгжүүлэлтийн зардлыг нэмэх ёстой юм. Хөрөнгө оруулалтыг нэмэх ёстой юм гэсэн байр суурь илэрхийлээд илэрхийлээд байгаа нь ийм учиртай шүү. Нөгөөтээгүүр бас энэ боломжоо төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бас бий болгох зорилго тавьж байгаа нь энэ хуулийн бас нэг зорилго юм уу гэж харж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганмаа гишүүний минут тодруулга нь дуусчихсан. Би өмнөөс нь тодруулчихъя. Мөнхтөр дарга аа, түрүүн Рэгдэл гишүүн ярьсан шүү дээ. Шинжлэх ухааны байгууллага 1 бол их сургууль дагасан байдаг. 1 бол Шинжлэх ухааны академи дагасан байдаг. Монгол Улсын одоо явуулж байгаа шинжлэх ухааны талаар ярьж байгаа бодлого нь аль нь юм. Танай яам дээр 1 жил хагасын өмнө очсон. Одоо аль хэдийн тэр бол бүр тов тодорхой байдаг байлгүй дээ. Аль нь юм.

Б.Мөнхтөр: Яг одоогийн байдлаар би бол зүгээр бүтэц талаас нь хэлье. Ер нь бол их сургуулийн хажууд шинжлэх ухааны хүрээлэнгүүд байж л байна. Академийн хүрээнд ч байж л байна. Академийн 16 хүрээлэн бол байж л байна. Нөгөөтээгүүр төрийн захиргааны байгууллагууд дээр бас хүрээлэнгүүд байж байгаа гэхээр шууд ийм юм, тийм юм гэж хэлэхэд бол хэцүү. Тэгээд аль аль хүрээлэнгүүд нь өөрөө онцлогоосоо хамаараад суурь болон иргэний судалгааг бол аль аль нь хийгээд явж байгаа гэж хариулъя.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгээд яах вэ асуудал нь энэ дээр л байгаа байхгүй юу. Аль алийг нь хийгээд, аль нь ч үгүй хоцордог. Та түрүүн өөрөө төсөв байхгүй гэж ярьж байна. Төсөв тавих нь танай яамны болон Засгийн газрын өөрийнх нь үүрэг. Нэгэнт хөгжүүлнэ гэсэн бол академитай байна гэсэн бол төсвөө өгөх нь үүрэг нь, цалингаа өгөх нь үүрэг нь. Тэгээд яг тэр төсвөө нөхөх арга нь иймэрхүү маягийн ажилд оруулчихаад, тэгээд аж ахуйн тооцоотой юм шиг ажиллаад ингээд болчих болов уу гэдэг байр суурийг би Монгол Улсын Засгийн газар бариасай гэж бодохгүй байгаа байхгүй юу. Ингэж явах юм бол бид нар шинжлэх ухаан ч үгүй худалдан авах ажил ч үгүй, төсөв ч үгүй, үр дүн ч үгүй, технологи ч үгүй л болчих болов уу. Яг ингэж л яваад байна л даа. Тэгэхээр би дараагийн удаа бас яг нэгдсэн чуулган дээр асууна гэж бодож байна. Сайдаас чинь асууя гэж бодож байна. Яг аль чиглэлийг нь бариад явж байгаа юм бэ. Тэгээд аль ч үгүй байх чинь Монгол Улсын асуудал болчихоод байгаа юм. Тэгээд өнөөдрийн шийдэж байгаа, бид нарын ярьж байгаа асуудал бол дандаа яг өнөөдрийнхөө асуудал, өнөөдрийнхөө тогтолцоо дээр аж ахуйн асуудлыг шийдэхийн тулд ингээд хуулийн өөрчлөлт хийгээд байгаа байхгүй юу. Цаанаа яг шинжлэх ухааныг хөгжүүлэхийн тулд жишээлбэл хувийн хэвшлийн шинжлэх ухааны байгууллага гэж байх юм уу, байхгүй юм уу. Байх юм бол яагаад төрийнх гээд ялгаад өөр заалт үйлчлүүлчхээд байгаа юм. Хэрвээ байхгүй гэвэл төр даасан шигээ даагаад явна. Байна гэвэл байдаг арай өөр бодлого л байх санагдаад байна. Тэр нь болохоор танай яамнаас болон энэ дээр гаргаж байгаа санал дээр ч гэсэндээ тиймэрхүү байдлаар 1 ерөнхий биш тов тодорхой бодлоготой л баймаар санагдаад байх юм. Ялангуяа танайх чинь Эдийн засаг бас хөгжлийн яам байх. Та хариулах гээд байна тийм үү. Микрофон 6.

Б.Мөнхтөр: Мэдээж шинжлэх ухаан, технологийн салбарын харилцаа бол төр ч энэ дээр ч тодорхой чиглэлийн судалгаа хүрээлэнгүүдээ авч явна. Хувийн хэвшил бол энд ямар нэгэн зөрчилдөх юм байхгүй. Хувийн хэвшлийн хүрээнд бол маш олон шинжлэх ухааны хүрээлэнгүүд, судалгааны төвүүд бол ажиллаад явж байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Тэгэхээр энэ хуулиараа хамгийн гол нь олгож өгч байгаа нь айтгар аргацаасан бол биш. Ер нь бол нөгөө энд чинь шинжлэх ухааны байгууллагууд дээр чинь нөгөө арга зүй нь байна, ажлын туршлага байна, хүний нөөц нь байж байна. Тэгэхээр энэ боломжуудаа ашиглаад тендерээр ажил авч чадахгүй байгаа энэ судалгааныхаа чиглэлээр оролцох энэ боломжийг нь хөнгөвчлөх л зохицуулалт байгаа. Тэрнээс биш төр бол угаасаа бодлогоороо бол мэдээж цаашдаа энэ салбараа дэмждэгээрээ дэмжинэ. Хөрөнгө оруулалтыг нь нэмэгдүүлэх арга хэмжээ бол авдгаараа авна. Өшөө бодлого зохицуулалт, хууль тогтоомж талдаа шаардлагатай арга хэмжээг бол авдгаараа авна гэдгээ бол илэрхийллээ. Миний түрүүний илэрхийлэл арай жоохон бас ойлголтын зөрүү үүсгэчихсэн юм шиг байна гэдгийг танд хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Уянга гишүүн.

Б.Уянга: Ганмаа гишүүний сүүлийн асуултад хариулъя. Эрдэм шинжилгээний нэгдсэн мэдээллийн сантай байгаад тэрэндээ яг ямар судалгааг яаж оруулах вэ гэдгийг нь дэлгэрүүлж энэ Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмж өгч байгаа. Тэгээд тэр нь ямар асуудал байгаа вэ гэхээр ер нь улсын төсвөөр хийгдэж байгаа судалгаа, эрдэм шинжилгээний, шинжлэх ухааны судалгаанууд бол нээлттэй иргэддээ ашиглуулдаг байж гэж байгаа юм. Олон улсын импакт фактортай ч юм уу ямар нэгэн сэтгүүлд хэвлүүлээд, тэр нь бид нарт ашиглагдах бус хэрвээ л улсын төсвөөр хийгдсэн ажил байвал нууцад хамаарахаас бусад мэдээллийг нь ил тод байлгая гэж байгаа. Одоогийн байдлаар бол энэ нэгдсэн мэдээллийн сан Шинжлэх ухаан, технологийн сан дээр бол байдаг. Тэгээд сая Мөнхтөр даргын газрынхан бас хамаараад явж байгаа. Тэгэхдээ ер нь бол шинжлэх ухааны байгууллагууд аль яам дээр харьяалагдахаас үл хамаараад Засгийн газар бүх энэ улсын төсвөөр хийгдэж байгаа судалгааны ажлуудыг нэгтгэдэг бай гэсэн агуулгыг нэмж тусгаж өгч байгаа. Давхардуулахгүй үүднээс нэмээд 1 юм хэлж болох уу.

Б.Найдалаа: 1 минут.

Б.Уянга: Энэ хууль дээр энэ хууль дээр ажилласан гол шалтгаан нь сая бол эрдэм шинжилгээний үр дүнг нийтэд нээлттэй байлгая. Нууцлахаас бусад мэдээллийг 1 дүгээр том зорилго.

Хоёрдугаарх нь болохоороо одоо ерөөсөө улсын төсвөөр зарлагдаж байгаа судалгааны ажилд их дээд сургуулиуд орж чадахгүй байгаа шүү дээ. Батзул дарга аа, ШУТИС орж чадахгүй байна. МУИС орж чадахгүй байна. Та хэллээ л дээ. 42 дээр болон 14 дээр зохицуулалт даатгалаар ингээд зохицуулна гээд. 2024 оны 1 сарын 1-ээс хойш тэгвэл яагаад хэрэгжихгүй байгаа юм. Тэгээд танай газрыг бол эрдэм шинжилгээний байгууллагуудыг ойлгодоггүй биш харин дэмжээд худалдан авахын хууль дээр ч гэсэндээ тендерт орж байгаа эхний баталгааг нь авахгүй энэ тэрээ гэсэн хуулийн заалтууд орж ирж байгааг бол мэдэж байгаа. Гэхдээ олон төрлөөр огт энэ эрдэм шинжилгээний байгууллагууд төрийн статуст эрдэм шинжилгээний байгууллагууд тендерээр зарлагдаж байгаа ажлыг авч чадахгүй байгааг л засъя гэж байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Бум-Очир гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүнээс эхэлнэ. Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Яг энэ заалтыг бас их дээд сургуулийнхантай манай бас нэр бүхий гишүүд уулзаж байсан. Рэгдэл гуай, Зүлпхар гишүүн, Галбадрах энэ тэр гээд. Яг энийг л тавьдаг юм байна лээ. Шинжлэх ухааны байгууллагууд их дээд сургуулиудыг бие даан хөгжих боломжийг нь нэг талаараа бид нар маш олон хуулиар ингээд хаагаад хаячихсан. Төрийн өмч нэрийдлийн доор. Тэгээд яаж одоо юманд ордог вэ гэхээр тодорхой хэсэг профессор эрдэмтэд нь бараг хувиараа шахуу нууц ч юм шиг. Тэгээд энэ бол томоохон хэмжээний судалгаа юутай холбоотой бүрэн потенциал нь байгаад байдаг. Тэгээд тендерийн баталгаа гаргах хэрэгтэй болно. Гүйцэтгэлийн баталгаа гаргах болно. Өмчөө барьцаалахаар болно. Төрийн өмчийг барьцаалж болохгүй гэдэг хууль нь чагттай. Тэгээд энийг шийдээд өгөөч гээд тавьсан. Тэгээд тендерийн хууль буюу төрийн болон орон нутгийн өмчөөр бараа худалдан авах энэ ажлын хэсэгт би бас ажиллаж байгаад энэ саналыг бас оруулах саналыг уг нь өгөөд, одоо яг яаж эцсийн байдлаар туссан манай Батзул эд нар бол мэдэж байгаа. Бид нар бас оруулаад тавьчихсан. Энэ дагнасан буюу

шинжлэх ухааныхаа хуульд нь давхар оруулж ирье гэдэг дээр манай гишүүд бас оруулж ирж байгаа юм байна.

Тийм учраас бол хуулийн төслийг бол бид нар ямар ч байсан явуулаад, харин тэр Батзулын хэлж байгаа ямар зөрчил байгаад байна. Логикийн магадгүй хүн өнгөц харахад үг хэллэг юуны хувьд бол ингээд зөрчилдөөд байх асуудал байвал энийг нь засаад явуулах хэрэгтэй болов уу гэж би бодож байна. Одоо 2026 он гарах гэж байна. Нэлээн олон тендерүүд зарлагдана. Энд уг нь амжуулаад 1 ч гэсэн жилийн өмнө оруулаад энэ хүмүүсийг нэг талаар бол бараг амлалт өгчихсөн шүү дээ. Үндсэндээ эндээ ороод, тэгээд шинжлэх ухаан болон их дээд сургуулиудыг төрөөс дандаа санхүүжилт өгөөд байх биш, өөрөө чаддаг зарим юмнуудаа хийгээд ингээд яв. Гадаад, дотоодын ч гэсэн их, дээд сургуулиуд шинжлэх ухааны байгууллагууд хөгжсөн түүх нь энэ юм байна лээ. Тийм учраас энэ хүмүүсийг бид нар бол хэт өндөр цалин бол өгч чадахгүй. Магадгүй бид нар бэлдсэн шинжлэх ухааны ажилтнууд, их дээд сургуулиудынхаа чадалтай мэдлэгтэй хүмүүсээ гадаад дотоод руу өөр салбарууд руу алдах ийм эрсдэлтэй юм байна лээ. Ингэснээрээ бол манай боловсролын салбар бол ирэх жил боловсролын жил болж байгаатай холбоотойгоор зөвхөн боловсролын салбарын бие даан хөгжих энэ боломж бололцоог нь бол энэ хуулийн дагуу хийгээд явуулъя гэдэг ийм саналыг бол бас хэлмээр байна.

Тэр даатгалын болон яах вэ бусад тэр хөнгөлөлт дэмжлэгээр хийж байгаа ийм зүйлүүдийг нь нэгтгээд магадгүй Худалдан авахын хууль чинь бас давхар удахгүй орох байх. Тэгэхдээ энэ заалт нь бол түрүүлээд явж байсан нь дээр болов уу гэж бодож байгаа юм. Магадгүй энэ худалдан авалтын хууль өөрөө том учраас маш олон зүйлийг нэг хуулиар зохицуулах гээд галтай хууль учраас удаж магадгүй гэдэг ийм болгоомжлол бол байна. Тийм учраас бол яах вэ, энэ дээр нь саяын тэр Батзулын хэлдэг энэ асуудлууд дээр анхаараад худалдан авалтын хууль дээр аль талаас нь оруулсан байгаа билээ нийцүүлээд, тэгээд гол ерөөсөө шалтгаан нь ерөөсөө л тэр. Тийм үү. Төрийн байгууллагууд болон хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд бол чөлөөтэй орж болж байгаа. Гэхдээ зүгээр нөгөө баталгаанаас нь хөнгөлнө гэдэг зүйлийг нь харин төрийн өмчийн байгууллагууд нь ямар ч баталгааны хөнгөлөлтөөс чөлөөлөгдөөд нөгөө хувь болон төрийн бусууд нь чөлөөлөгдөнө гэдэг үгний юман дээр наана цаана юм байгаад байх шиг байна. Тэгээд энэ тал дээрээ бол би анхаараад шийдчихвэл их айхтар зөрчил гарахгүй болов уу гэж бодож байна.

Тэгээд шинжлэх ухааны байгууллагууд, их дээд сургуулиуд маань цалин хөлсөө нэмэгдүүлэх, нийгмийн хамгаалаад шийдвэрлэх гэхээр үндсэндээ бараг их дээдүүд бол оюутныхаа төлбөр дээр л тавьдаг. Тэгээд бид нарыг очихоор цалин нэмээд өгөөч гэдэг. Бид нар нөгөө талдаа оюутны төлбөр нэмж болохгүй гээд ингээд хаячихдаг. Тийм учраас энэ тал нь бол цаана цаанаа маш олон их, дээд сургуулиудын чадавх, мөн нийгмийн асуудлууд, шинжлэх ухааны байгууллагууд өөрсдөө орлогоо олоод, цаашаагаа хөгжөөд явах энэ боломжийг нь нээж өгөх ийм чухал хуулийн заалтууд байна. Тэгээд үзэл баримтлал юуны хувьд бол дэмжиж байна. Тэр үг, үсэг дагаж гарч болох зарим нэгэн зөрчлийн юмыг нь бол засаад явчихад бол болох болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна. Монголд дээд боловсрол хөгжихгүй байгаа хэд хэдэн шалтгаан байдаг. Тэрний нэг

нь энэ шүү дээ. Өөрсдийн нь мөнгө олох бүх гарц гаргалгааг нь хаачихсан. Тэгээд сая Эрдэнэбат гишүүн хэлж байна шүү дээ. Тэгээд ерөөсөө зөвхөн оюутны төлбөрөөр л санхүүждэг. Бараг 90 хувь байна уу. Миний мэдэхээр лав 90 гаруй, 100 хувь байсан. Одоо ч манай их сургуулиуд ийм байгаа. Төрөөс дэмжлэг өгдөггүй. Тэгээд тендерт нь ороод юм авъя гэхээр тэр нь бас хязгаарлагдмал. Яг энэ хуулийн төсөл дээр байгаа. Тэгээд Уянга гишүүн түрүүн уг нь тов тодорхой хэллээ шүү дээ. Энэ төрийн өмчит их сургуулиудад давуу тал олгох гээд байгаа хэрэг биш харин эрх нь хязгаарлагдчихаад байгааг нээж өгөх гээд байгаа юм гээд тов тодорхой хэллээ шүү дээ. Тэгэхээр би бол энэ төслийг дэмжиж байна.

Яагаад дэмжиж байгаа вэ гэхээр өдий болтол Монголын их дээд сургуулиуд, их сургуулиуд, тэнд байгаа эрдэм шинжилгээний байгууллагууд, ер нь Монголын шинжлэх ухаан хөгжихгүй байгаад байсан, хөгжиж чадахгүй байгаад байсан, гацаагаад байсан олон шалтгаануудын хэд хэд нь лав энэ дотор явж байна. Саяынх бол 1 нь байх жишээтэй. Тийм учраас энийг дэмжээд бид нар бас явах ёстой болов уу гэж бодож байна.

Бас нэг зүйл энэ дээр яригдаад байх юм. Төрөөс шинжлэх ухааныг дэмжих ёстой. Ялангуяа төрийн өмчит боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудыг дэмжих ёстой. Тэр хувийн хэвшлүүдийн тухай бид нар дараа нь ярья тэгэх үү. 4 байгууллага байна гээд сая хэллээ шүү дээ. Төрөөс улс орон байгаа бол тэр улсад байгаа шинжлэх ухааныхаа салбарыг тэр улс тэр төр нь дэмжих ёстой. Энэ шинжлэх ухааныг дэмжиж байгаа хэрэг шүү. Тэнд маш олон инновац, тэгээд маш олон нээлт, юу ч байхыг үгүйсгэхгүй. Тэгээд энэ байгууллагууд бол мөнгө олдог байгууллагууд биш шүү. Шинжлэх ухааны байгууллагуудыг бид нар мөнгө олохыг шаардаад байдаг юм. Мөнгө олохгүй шинжлэх ухааны байгууллага байна гээд хаачих гээд байгаа байхгүй юу. Суурь шинжлэх ухааныг мөнгө олсон, олоогүй бид төрөөс бодлогоор дэмжиж байх ёстой гэдгийг би онцгойлон хэлмээр байгаад байна. Нэгэнтээ яг өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудал маань энэ Монголын дээд боловсрол, шинжлэх ухааны хөгжилтэй, тогтолцооны асуудалтай холбоотой юм болоод явчихлаа л даа. Хэрвээ бид нар энэ шинжлэх ухаан, дээд боловсролоо үргэлжлүүлээд дэмжмээр, хөгжүүлмээр байгаа бол хэд хэдэн зүйлсээ засмаар байна.

1 дүгээрт бид нар энэ шинжлэх ухаан гэж нэрлэгдээд байгаа шинжлэх ухааны академи болоод эс үгүй бол их сургуулиуд гэсэн энэ 2 яам дээр хуваагдчихсан байгаагаа одоо Засгийн газар эргэж хармаар байна. Нэг хэсэг нь дээд боловсрол гэдэг агуулгаар Боловсролын яаман дээрээ үлдчихсэн. Нэг хэсэг нь эдийн засаг дээр гээд ингээд хуваачихсан. Энэ бол ирээдүйд бол илүү би бас тухайн үед нь ч хэлж байсан. Энэ бүтцийг эргэж хармаар байна. Ингээд бид нар шинжлэх ухаанаа 2 хуваачхаад цааш нь яаж хөгжүүлэх тухай асуудал ярих гээд байгаа нь жаахан ойлгомжгүй байгаад байгаа юм. Энийгээ нэгдсэн бодлоготой, нэгдсэн бүтэцтэй, нэгдсэн институттэй болгож байж явахгүй бол ингээд 2 хэсэгт хуваачхаад шинжлэх ухаан, дээд боловсролоо хөгжүүлнэ гэдэг бол байж боломгүй зүйл болов уу гэж бодож байна.

Тэгээд Найдалаа дарга түрүүн асуугаад байна шүү дээ. Шинжлэх ухааны академи суурьтайгаар шинжлэх ухаанаа хөгжүүлэх гэж байгаа юм уу. Их дээд сургууль суурьтайгаар хөгжүүлэх гэж байгаа юм уу гээд ингээд дунд нь яг үнэнийг хэлэхэд маш олон жил бид нар ийм гацаатай байж ирсэн шүү дээ. Тэгээд тэр Шинжлэх ухааны академи суурьтай гэдэг нь яг үнэнийг хэлэхэд хуучин социалист маягийн л тогтолцоо шүү дээ. Барууны орнууд бүгд л их сургууль дээрээ шинжлэх

ухаан нь төвлөрчхөж байгаа шүү дээ. Бритиш академи гээд байж байна. Британийн академи хэзээ тэнд судалгаа хийж байсан юм. Дандаа менежментийн ажил, санхүүжилтийн ажил хийдэг шүү дээ гэх мэтчилний ийм зүйлс байгаад байгаа юм.

Дараагийн нэг зүйл нь бол би Боловсролын яамнаас их олон удаа асууж байгаа даа. Энэ судалгааны их сургуулийн тухай хуулиа оруулж ирээч ээ. Энийг чинь ингээд хуулиараа аваачаад зөвхөн энэ Засгийн газраас орж ирэх ёстой чиглэлийн яам нь оруулж ирэх ёстой гээд заачихсан. 1 удаа өнгөрсөн парламентаар бол энийг оруулж ирэх гээд уначихсан. Энэ судалгааны их сургуулийн тухай хуулиа 1 талдаа гаргаж байж бид нар энэ хөгжлийн асуудлаа цааш нь ярих боломж нээгдэх гээд байна л даа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганмаа гишүүн үг хэлнэ.

Д.Ганмаа: Шинжлэх ухааны бодлого нь ер нь бол Монгол Улсын хөгжлийн үндсэн хөдөлгүүр байх ёстой. Энэ хуулийн зорилго нь шинжлэх ухааны салбарын бүтцийн асуудал, тогтолцоо гэхээсээ илүү улс орны тэр өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, зайлшгүй шаардлагатайг нь олох, тогтоох, эрэмбэлэх, тэрний дагуу шинжлэх ухаан, санхүүжилт, мөнгө төгрөг, хүний нөөц, тэр дээр нь анхаарах хэрэгтэй байх. Энэ хуулийн төслийн зорилго, хэрэгжилт, хариуцлага гэсэн ийм гуравласан уялдаа байвал их зүйтэй санагдаж байна. Үүний уялдааг нь арай сул байгаа юм болов уу гэж харлаа. Тэгэхдээ энэ магадгүй нөгөө өөрчлөлт дээрээ биш гол хууль дээрээ ямар орсон юм байгаа юм.

Энэ засаглал бүтэц институцийг сая бас гишүүд нэлээн их ярилаа л даа. Шинжлэх ухааны академи нь тэгээд ер нь бүгд л санал нэгдэж байгаа юм нь Шинжлэх ухааны академи, яам, тэгээд их сургууль, магадгүй нэг хэсэг технологийн паркууд гэж ярьж байсан. Эд нарын үүргүүд нь тодорхой биш байна. Давхцаж байна гэсэн ийм санаануудыг хэлж байна. Ер нь миний санаа бол бас энэ судалгааны бодлого хариуцсан тусгай national research council гэдэг шүү дээ. Жишээлбэл Англид бол. Эсвэл эрүүл мэнд дээр бол national institute of health гэдэг шиг ийм тусгай бүр ингээд бодлогыг нь тодорхойлсон ийм хариуцлагатай тийм институц юм уу тийм загвар баймаар санагдаад байна. Тэгснээрээ энэ их сургууль, эрдэм шинжилгээ, дээрээс нь хувийн хэвшлийн уялдааг ч гэсэн хангаж оруулж ирэх, магадгүй түрүүн миний дахин дахин асуугаад байсан тэр researching development-ийг оруулах, тэгснээрээ тэнд ажиллаж байгаа эрдэмтдийн лиценз авах, патенттай болох, роялтыгаа авах гээд ингээд санхүүгийн өөрийнх нь хөшүүргийг бий болгох, тэгээд мөн энэ суурь судалгаа дээр бол аргагүй төр мөнгөө гаргах хэрэгтэй. Санхүүжилтээ өгөх ёстой. Энэ нь дутуу ч байгаад байдаг.

Тэгэхдээ үүнээс дээшээ бүр технологийн хувьд шинжлэх ухааны үнэхээр инновацын хувьд ярьж байгаа бол эрдэмтдийн зүгээр цалин өгөх асуудал огт яригдах ёсгүй байхгүй юу. Зүгээр сууж байгаад цалин авна гэсэн ойлголт байхгүйгээр үнэхээр шаардлагатай, хэрэгтэй энэ санхүүжилт нь өгдөг энэ нөхцөлийг бүрдүүлэх, түрүүний хэлсэн өрсөлдөөнт чанарыг бий болгох, энэ нь олон нийтэд ил тод байх. Одоо жишээлбэл юу гэдэг юм элэгний хавдраар нас бараад л байна. Элэгний хавдрын нас баралт хамгийн өндөр байгаа бол энийг бууруулах хамгийн гол интервенц нь юу юм бэ гэдэг зарлалыг шууд тавиад, тэр дээр ингээд яг адилхан реер review оруулаад, тэндээсээ хамгийн гол, хамгийн зөв, хамгийн хэрэгжихүйц боломжтойг нь тооцоолж гаргаж ирээд, энэ дээрээ санхүүжилтээ өгөөд, энэ дээр нь өвчлөлөө бууруулаад явах ч юм уу одоо ингээд наад захын зайлшгүй хэрэгтэй юмнууд зөндөө байгаа байхгүй юу.

Тэрний хажууд бид нар эрдэм шинжилгээ ярихаар энэ гранд менежмент ч юм уу, эсвэл хажууд нь байгаа operational team-ийг ерөөсөө ярихгүй хаячхаад байдаг юм. Эрдэмтэд өөрсдөө энийг чинь бүгдийг нь хийх албагүй хажууд нь заавал operational team нь санхүүг нь бодож өгдөг, энэ indirect cost-ийг нь тооцоолдог, энэ дээр нь бүтцийг нь бий болгодог энэ дэд бүтцийг нь зайлшгүй бий болгож байж энэ эрдэм шинжилгээ, энэ технологи, энэ шинжлэх ухаан чинь амьдрал дээрээ дээрээ хэрэгжиж явах боломжтой энэ загвар бүрдэнэ гэдгийг бас анхаарвал хэрэгтэй байна.

Гадаадад ажиллаж байгаа Монгол эрдэмтэд гэж олон хүмүүс байгаа. Эд нарыг бас тогтвортойгоор ул суурьтайгаар институцийн хамтын ажиллагааг бүрдүүлэх гадаадад байгаа энэ эрдэмтдийнхээ ашиглах гэх юм уу даа оюутнуудтайгаа холбож өгөх faculty to faculty оюутан оюутантай энэ холбоог бий болгосноороо бид нар бас энэ чанарыг сайжруулах, энийг үр ашигтай болгох, сүүлийн үеийн шинжлэх ухааны техник технологи блогоос байнга зүүгдэх гэх юм уу даа. Дээрээс нь ил тод байдалтай, үр дүнтэй, энийгээ дүгнэж үнэлдэг энэ боломж нь бас бүрдэнэ гэдэг энэ саналыг бас хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Зулпхар гишүүн үг хэлнэ.

С.Зулпхар: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг дахин эрэмбэлье. Хууль санаачлагчдын энэ хуулийн төслийг бол бүрэн дэмжиж байна. Санаачилсан хуулийн төслийг. Түүнчлэн энэ хууль санаачилсан гишүүддээ бас талархсанаа илэрхийлье. Манай Байнгын хороо шинжлэх ухааны асуудлыг ингээд онцгойлон авч үзэж, гишүүд маань бас тал талаасаа саналаа илэрхийлж, мэдээж энэ хуулийг дэмжиж байгаа гэдгээ илэрхийлж байна. Бас тэрнээс гадна хуулийг илүү боловсронгуй болгох чиглэлээр саналаа илэрхийлж байгаа тийм сайшаалтай зүйл болж байна гэж үзэж байгаа юм. Бид яах вэ өнгөрсөн жил гаруй хугацаанд Улсын Их Хурлын гишүүд болсон. Тэрнээс хойш хугацаанд бас тодорхой түвшинд, төсөв мөнгөний хүрээнд шинжлэх ухааны салбар дээрээ илүү төсөв тавиулчих гээд л бас л тал талаасаа хичээсэн. Гарсан үр дүнгүүд бий. Гэхдээ бас гаргаж чадахгүй байгаа маш олон жишээ нь бэрхшээлүүд байгаа юм. Тэгэхээр энэ үүднээс энэ хуулийн төсөл бол цаг үетэйгээ уялдсан байдлаар нэг тодорхой асуудлыг л шийдэх гэж байгаа учраас бид энэ тодорхой асуудлыг нь шийдээд явах ёстой юм байна гэдэг ийм саналыг хэлж байна.

Сая Рэгдэл гишүүн бас хэлсэн. Би зориуд бас та бүхэнд статистикийг нь хэлье. Одоо манай төсвийн 0,12 хувь л байгаа шүү дээ. Тэгээд одоо 0,5 болгоод, 1 хувь болгоно гэдэг зорилтыг тавьчихсан. Шинжлэх ухааны салбарын зардлыг. Бид энийг цааш нь нэмэгдүүлэхийн төлөө чармайна. Мэдээж хэрэг хамтдаа. Тэрнээс гадна саяын төрийн худалдан авах үйл ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх боломжууд нь байгаад байхад тэрийгээ ашиглаж болдоггүй ийм хуулийн бас хаалтууд, хуулийн бас хязгаарууд байгаа бол энийг бид шуурхай шийдээд л явах ёстой. Энэ хууль бол тухайн тохиолдолд хэрвээ хэрэглэж болохгүй байгаа бол, ямар нэгэн зүйл дээр саад болж байгаа бол тэрийг шуурхай шийдээд, шинэ бодлогын боломж, эсвэл зохицуулалтын боломж олгох дээр Улсын Их Хурлын гишүүд санаачилгатай ажиллах ёстой бол энэ санаачилга нь бас болж байна гэж үзэж байгаа юм.

Сая хэлж байна энэ бизнесийн салбартай өрсөлдөх үү гэж. Тэгэхээр бизнесийн салбар бөгөөд шинжлэх ухааны салбар бол 2 өөр. Тэгэхдээ бас уялдаатай. Хэрвээ энэ RD байх юм бол энэ бол шинжлэх ухаан бизнестэйгээ уялдлаа гэсэн үг. Гэтэл

ерөөсөө шинжлэх ухаан бол бизнес биш байдлаар хийгддэг бас шинжлэх ухаанууд байна. Түүх өөрөө шинжлэх ухааны 1 зүйл. Түүх дээр энэ ямар нэгэн байдлаар бизнестэй бол адилтгах боломжгүй. Одоо хүн амын удмын сангийн асуудал судаллаа л даа. Судалж байгаа гэж бодъё. Тэгэх юм бол энэ дээр бизнесийн асуудал ярихаасаа илүүтэй цэвэр төрийн бодлогын асуудал яригдана гэж байгаа юм. Тэрнээс гадна манай Хууль зүйн үндэсний хүрээлэн энэ янз янзын төслүүд рүү орж чаддаггүй. Саяын хаалтаас болоод. Гэтэл яг судалгааны үндсэн чадавх бол тэнд байдаг их сургуулийн хуулийн том тэнхимүүд дээр байдаг. Тэд нар нь орж чаддаггүйгээс болоод тэр судалгааг яаж хийдэг вэ гэхээр зэрэг түрүүн Эрдэнэбат гишүүн бас сайн мэдэж байх шиг байна лээ. Янз янзын төрийн бус байгууллага байгуулаад, тэрүүгээр хийдэг. Тэр төрийн бус байгууллага чинь яадаг гэхээр зэрэг эргээд нөгөө судлаачидтай гэрээлж ажиллуулдаг ийм л юм хийж байгаа юм. Тэгэхээр бид эхлээд өөрсдөө байгаа нөгөө бодит нөхцөл байдлаа даван туулах тэр зүйлийг хийчхээд, шинжлэх ухаанаа хөгжүүлэх чиглэлээр тэрнээс гадна мэдээж хэрэг хувийн хэвшлийнхээ цаашдаа бас эрдэм шинжилгээний байгууллагууд бий болж байна шүү дээ. Тэд нарыгаа бас оролцох боломжийг нээсэн тэр эрх зүйн орчныг хангах ёстой гэж бодож байна. Энэ Худалдан авах үйл ажиллагааны газрынхан маань бас зөв л санал хэлж байгаа л байх л даа. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй гэж. Энэ шинжлэх ухаан бол ямар нэгэн байдлаар төрийн байгууллага мөртөө хувийн хэвшилтэй өрсөлдөөгүй. Энэ бол Монгол Улсад шинжлэх ухааныг л хөгжүүлж, мэдлэгт суурилсан байдлаар, магадгүй тодорхой салбарын шийдвэр гаргахад нь оролцох энэ нөхцөлөө л хайж байгаа юм.

Геологийн хүрээлэн энэ жил бид нар ингээд Геологийн хүрээлэн дээр сүүлийн 5 жил тавьсан зардлаа л тавьчихсан байгаа байхгүй юу. Зөвхөн цалинг нь тавьсан. Тэнд ямар ч судалгаа хийгдэхгүй. Судалгааны зардал тавиагүйгээс болоод Монгол Улсын тэргүүлэх чиглэл нь геологи юм билээ. Тэгсэн мөртөө геологи дээрээ бид нар өнөөдөр геологийн хайгуул судалгааны үндсэн үр дүн гаргаагүй, цаашаа хөгжлийн чиглэлийн суурь судалгаа хийгдээгүй, магадгүй зорилтот судалгаа хийгдээгүй яваад байгаа учраас энэ чинь өөрөө бэрхшээл болоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бүхнийг шийдэх үүднээс энэ хуулийн төсөл бол их ач холбогдолтой юм байна. .../минут дуусав/

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн үг хэлнэ.

О.Саранчулуун: Шинжлэх ухаан, судалгаа гэдэг асуудлыг ярихаар жил болгон их сургуулийн багш нар бол тайланг Засгийн газраас, Боловсролын яамнаас тайлан авдаг. Зүгээр их сургуулийн багш бол 3 янзын ажлаар багшийн оноонууд бий болдог. Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ гээд 3 зүйл. Тэгээд мэргэжлийн үйл ажиллагаа гэдэг юм заавал багшийн үйл ажиллагааны оноон дотор явдаг. Түрүүгээрээ багш, дадлагажигч багш, багш, ахлах багш зэргээр зэрэг нэмэгдээд явдаг ийм тогтолцоотой. Кредит нь ч гэсэн а, б цаг нь тэгж бүрддэг. Засгийн газрын төлөвлөгөө “2.2.7.төрийн өмчийн их сургуулиудыг сургалтын их сургуулиас судалгааны их сургууль болгон хөгжүүлж, академик эрх чөлөөг ханган инновацын эко системийг бүрдүүлнэ.” гэж төлөвлөсөн байгаа. Өнөөдрийн ярьж байгаа энэ асуудал түүнтэй ямар холбоотой эсэх дээр би бас тод сайн харж чадахгүй байна л даа. Нөгөө талд шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл дээр Засгийн газар 5 жил тутам тодорхойлж ингэж гаргаж ирдэг. Тэр дотор жишээлбэл саяхан батлагдсан 2026 он, 2030 онтой ямар уялдаатай, тэр дээр ямар ахиц гарах эсэх дээр бид нар харж байж ямар тендерийг ямар юман дээр хөнгөлөлт олох юм, юуг ногоон гэрлээр оруулах юм, оруулахгүй юм гээд ярих ёстой байх гэж бодоод байгаа.

Шинжлэх ухаан, технологийн тайланг Монголд ямар эрдмийн судалгаа байна, ямар сайн оноо ярих болохоор их сургуулийн багш нарын тайлангуудыг ашигладаг. Их сургуулийн багш нарын мэдээллүүд бүртгэгдээд явдаг мөртөө төсөл авах болохоороо төрийн том том юу гэдэг юм төсөл, Засгийн газрын том мега төслүүд рүү орох болохоороо их сургуулийн багш нарын оролцоо бүдэг болчихдог байхгүй юу. Тэр чинь шударга бус харагдаад байна шүү дээ. Ил тод байдал. Тэгэхээр би энэ хуулийг, одоо энэ оруулж байгаа өөрчлөлтийг бол ил тод байдлыг сайжруулах агуулгаар нь бол дэмжиж байна. Гэхдээ жишээлбэл бодъё л доо. Sudalгаа.gov.mn дээр жишээлбэл ил тод мэдээллээ оруулахгүй байна гэж байна. Яагаад би өнөөдөр Сайнтифик Репорт сэтгүүлд бичсэн өгүүллээ тэнд Гүүгл сколлероор хайхад харагддаг юмыг давхар би Засгийн газрын юм руу оруулах ёстой юм. Эрдэм шинжилгээ академи гэдэг бол өөрөө аяндаа бүртгэгддэг критериатай шалгууртай ийм л юм. Энийг нь заавал төрөөс тусад нь сайд гаргаж жагсаах хэрэг байгаа юм уу. Угаасаа ил тод байдалд төрийн өчнөөн л олон веб сайтууд байгаа шүү дээ. Тэр дээр төсөл нь байж байдаг. Эрдэм шинжилгээ нь угаасаа тусдаа энэ чинь ингээд либерал ийм зүйл шүү дээ. Энэ дээр мөнгө зарах хэрэг байгаа юм уу гэдэг нэг ийм бодол байгаад байна л даа. Олон улсад шалгуураа хангаж байгаа бол бүртгэгдээд явдаг ийм л тогтолцоо. Гүүгл сколлер гэдгийг бүгдээрээ хэрэглэдэг. Хүмүүс эрдэмтдийн тухай хайхдаа Гүүгл сколлераас хайдаг болохоос Засгийн газрын сайтаас хайхгүй шүү дээ. Мэдээлэл судалгааг.

Дээрээс нь тэнд чинь судалгааны чансаа гарч ирдэг байхгүй юу. Тэгэхээр багш нар өнөөдөр судалгааны их сургууль болно гэж ярьж байгаа учраас багшийн а, б цагийн төлөвлөгөө өнөөдөр судалгаа, тэргүүлэх чиглэл, эрдэм шинжилгээ, академик гэдэг үнэлгээгээр явж байхад яагаад гол судлаачид энэ хүрээлэн дээр байна. Гол судалгааны мэргэжилтнүүд энэ дээр байгаа багш нар хажуугаар нь хийх чадах эсэх дээр ийм эргэлзээтэй хариултуудыг манай энд байгаа эрдмийнхэн яагаад яриад байгааг би бас ойлгохгүй байна. Тэгэхээр энийг бид нар эргэж харж, тэргүүлэх чиглэлээ дахиж харах ёстой байх.

Дээрээс нь тэргүүлэх чиглэл дээр хэрвээ хүний эрхийг дээдэлсэн Засгийн газар бол энэ тэргүүлэх чиглэл дээр хүний эрхийн холбоотой судалгаанууд дээр одоо энэ чигээр нь цаашаа явлаа гэхэд хүний эрхийг дэмжсэн ажлууд дээр судалгаагаа грантаа өгдөг ч байдаг юм уу, тендерийн хөнгөлөлт байдаг ч юм уу ийм зүйл байгаасай гэж бодож байна. Ийм агуулга байвал дэмжиж оролцох ийм бодолтой байна. Үгүй бол энэ чинь хэсэгчлээд л яваад байгаа байхгүй юу. Тэгээд багшийн статус ч гэсэн энэ байгууллагуудын хооронд гараад байгаа. Тэгэхээр Найдалаа гишүүний асуулттай би яг адилхан байна. Бид нар аль чиглэлээ барьж байгаад явах юм. Ингээд эвдэрхий юмаа нэг хэсгийг нь засчхаад, эвдэрхийгээр нь цаашаа яваад байх уу. Тогтолцоогоо засах уу гэдгийг ярих ёстой байх гэж бодож байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Би эцэст нь бас саналуудаа нэгтгээд, товч үг хэлье. Хуулийн төслийг бол дэмжиж байна. Гэхдээ энэ бол түрүүн би хэлсэнчлэн яг ингээд сууриар нь том бодлоготойгоо уялдаад тааруутай. Гэхдээ өнөөдрийн тулгамдаж байгаа аж ахуйн асуудлыг шийдэхийн тулд явж байгаа хуулийн төсөл байна. Тэгэхдээ өнөөдрийнхөө нөхцөл байдалд бол яах аргагүй явуулсан нь зөв байна. Харин зүгээр цаашдаа тэр шинжлэх ухааны хөгжүүлэх, дэмжих бодлого гээд байгаа зөндөө юм ярьж байгаа. Зөндөө юм бичсэн байгаа. Гэхдээ яг бодитойгоор юу юм бэ гэдгийг бид нар дахиад өргөж аваад, цэгцлэхгүй бол болохоо байжээ. Түрүүн гишүүд хэлж байна. Шинжлэх ухаан ба боловсрол 2 нь тусдаа тусдаа өөр яам хариуцдаг ямар улс байна. Энэ 2 салдаг ямар эд зүйл байна. Энэ чинь угаасаа утгагүй зүйл

байгаа байхгүй юу. Шинжлэх ухаан, боловсрол 2 1 зоосны 2 тал. 2 тал биш бараг 1 зүйл байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг нэгтгэхгүй бол болохгүй нь ээ.

2 дугаарт түрүүн хэлсэн тэр шинжлэх ухаанд суурилсан юм уу, их сургуулиудад суурилсан шинжлэх ухааны бодлого байх юм уу гэдгээс бас их юм хамаарах гээд байна. Хэрвээ тэрийгээ тодорхойлохгүй бол ингээд аль нь ч мэдэхгүй байна гээд яваад байх юм бол бид нар шинжлэх ухааны зардлыг нэмэх тухай ярих боломжгүй, утгагүй. Өнөөдөр төсвөөс бага зарцуулж байгаа үнэн. Гэхдээ нэмэх боломжгүй шүү дээ. Яагаад гэвэл цаана нь байгаа тэр бүтэц нь өөрөө хуучин нийгмийнхээрээ асар их үрэлгэн, үр ашиг муутай, тэгээд өнөөгийн 21 дүгээр зууны шинжлэх ухааны хөгжлийн хэрэгцээнд нийцэхгүй байгаа байхгүй юу. Нийцэхгүй юмыг мөнгө хийгээд байх юм бол тэр төсвийг бид нар хэзээ ч дийлэхгүй. Монгол Улс. Одоо яг манай Байнгын хороонд байгаа асуудлууд дандаа ийм асуудлууд байгаа. Нийгмийн хөгжилтэй холбоотой болохоор бүтэц нь хуучнаараа хэр нь хэрэгцээ нь шинээрээ гарчихсан. Хуучин бүтцээ хуучин 1985 онд үйлдвэрлэсэн машиныг өнөөдрийн бензинээр цутгаад байгаатай адилхан зүйл байгаа байхгүй юу. Асар их иднэ тэр машинууд. Тэгэхээр жишээлбэл соёлын төвийн асуудал байдаг. Соёлын төв үнэхээр хэрэгтэй. Гэхдээ яг хуучин загвараараа улаан булангаа өргөжүүлээд, театр болгож бариад байх юм бол Монгол Улсын төсөв дийлэхгүй. Тэгэхээр тэрийгээ өөрчлөөд, иргэнд хүрсэн тэр соёл, боловсрол, урлаг бүгдийг нийлүүлсэн ийм шинэ маягийн бүтцэд оруулахгүй бол бид нар дийлэхгүй болчхож байгаа юм. Тэгэхээр яг энэ шинжлэх ухааны хөгжил бол яг тийм байна. Тийм болохоор Эдийн засаг, хөгжлийн яам болон Боловсролын яам ер нь бол Засгийн газар энэ дээр дорвитой бодлогын, зарчмын өөрчлөлт хийхгүй бол төсөв бага байна гээд тэр бол өнөөдрийн шийдэх асуудал биш болчхож байгаа юм. Хэрвээ одоогийн бүтцийг бол бид нар яг үнэнийг хэлэхэд энэ чигээр нь санхүүжүүлэх юм бол Монгол Улсын төсөв дийлэхгүй, утга ч байхгүй. Тэгэхээр яг энэ талаар бодлогын өөрчлөлт гаргаасай гэж бодож байна.

Тэгээд ер нь зүгээр бас нэг бодмоор зүйл. Одоо нэгдсэн хурал дээр гишүүд бас асуух байх л даа. Зөв юм шиг боловч яагаад шинжлэх ухааны байгууллагыг дэмжье гэж байгаа юм бол төрийн өмчит болон төрийн өмчит бус гэж ялгаад байгаа юм бэ гэдэг чинь өөрөө хариулт байхгүй л байгаа байхгүй юу. Яагаад ялгаж байгаа билээ ингэхэд. Төрийнх бол сайн гэж байгаа юм уу, төрийнх болохоороо төсөвгүй гээд байгаа юм уу. Харин тийм. Тэгэхээр тэгээд хувийнх нь орохгүй байгаа юм уу, орох хэрэггүй юм уу гэхээр ингээд ерөнхийдөө цаашдаа энэ зарчим чинь өөрөө буруу болчхоод байгаа юм. Бүх юман дээр ингэж хандаж эхэлж байгаа байхгүй юу. Хэрвээ зүгээр төрийнхийг орохыг нь эрхээр нь хуулиараа хаалттай бол нээгээд, харин цаанаа тэр санхүүгийн хөшүүрэг бэрхшээл байгаа бол тэрийг Академи нь, Засгийн газар нь, яам нь, эсвэл тэр сургууль нь өөрөө тэр төсвөөрөө шийддэг механизм нь арай өөр маягаар шийдэхгүй бол төрийнх болохоороо ингэж байгаа тэр логик нь болохгүй байна гэж би хэлээд байгаа юм. Түүнээс дэмжихийг бол дэмжиж байна. Тэгээд энэ дээр бол жоохон бодоод, ажлын хэсгийнхэн болон хууль санаачлагчид хариултаа бэлдээд, ялангуяа яамд маань тэр бодлогын чанартай асуудал дээр уялдаа холбоог нь сайн гаргаж өгөхгүй бол нэгдсэн хуралдаан дээр сорилтод учрахаар юм шиг байна шүү. Баярлалаа.

Одоо дэгээрээ Рэгдэл гуай энэ дээр дэгээрээ болохгүй болохоор Рэгдэл гуай та нэгдсэн хуралд ороод хэлчихгүй юу даа. Би энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд зүгээр мэдэхгүй энэ дээр ингээд яриад хэдүүлээ хоорондоо маргах нь нөгөө дэгээрээ болохгүй болохоор энэ бол ямар ч байсан нөгөө надад өгсөн мэдээлэл дээр үндэслээд, миний бодол, байр суурь яг ийм л байна гээд л бодчихгүй юу.

Тэгээд та бүхэн тэгээд дараагийн юун дээрээ санал хураалтаараа болон нэгдсэн хуралдаан дээрээ байр сууриа илэрхийлээд явж болох байх. Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтад гишүүд бэлэн болсон байна. Эхний санал хураалт.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 64,7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 58,8 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийнх Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 64,7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг төсөл тус бүрээр санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулна. Танилцуулах гишүүн Зулпхар гишүүн танилцуулна. Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.26 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ